

МОНГОЛ УЛС

**УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ
ДЭМЖИХ ТӨСӨЛ (P118109) БА УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ- НЭМЭЛТ
САНХҮҮЖИЛТ (P145439)**

**ХЯНАЛТЫН ХОРООНЫЭЦСИЙН БӨГӨӨД
ГУРАВДУГААР ТАЙЛАН БАЗӨВЛӨМЖ**

2017 оны 7 дугаар сарын 13

ДЭЛХИЙН БАНК

Хяналтын Хорооны болон Удирдлагын баримт бичгүүдийн орчуулга нь албан бус орчуулга бөгөөд зөвхөн сонирхогч талуудад зориулсан болно. Эх материалыг зөв хөрвүүлэх тал дээр чармайн ажилласан болно. Орос, монгол хэлний орчуулгын хувьд ямар нэг зөрүү гарах тохиолдолд англи хэл дээрх баримт бичгүүдийн эхийг баримтална.

Хяналтын хорооны эцсийн бөгөөд гуравдугаар тайлан ба зөвлөмж

МОНГОЛ: Уул Уурхайн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Төсөл (P118109) ба Уул Уурхайн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Төсөл- Нэмэлт Санхүүжилт (P145439)

А. Оршил

1. Хяналтын хороо (“Хороо”) нь Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл” (P118109) болон “Уул уурхайн дэд бүтцийн Хөрөнгө Оруулалтын Дэмжих Төслийн Нэмэлт санхүүжилтийн төсөл” (P14539) (цаашид “МИНИС” эсвэл “Төсөл” гэх)–ийн санхүүжилтийн хүрээнд явагдаж буй үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй хор хохирлын талаар санаа зовниж буй Монгол, Орос иргэдийн төлөөллүүд болон орон нутгийн байгууллагуудаас 2015 оны 2 дугаар сарын 10-нд хүсэлт хүлээн авсан. Хүсэлт гаргагчид Хорооноос мэдээллийн нууцыг хадгалахыг хүссэн ба хүсэлттэй холбоотой асуудлаар өөрсдийг нь төлөөлөн харилцах “Хил хязгааргүй гол мөрөн” байгууллагын Монгол болон Орос дахь 2 төлөөлөгчийг томилсон.

2. МИНИС нь 2011 оны 5 дугаар сарын 10-нд Захирлуудын зөвлөл (Зөвлөл)–өөр батлагдсан Олон улсын Хөгжлийн Ассоциацийн 25 сая ам. долларын зээл болон 2014 онд батлагдсан 4.2 сая ам. долларын нэмэлт санхүүжилтээр хэрэгжих техникийн туслалцааны төсөл юм. Төслийн хөгжлийн зорилтууд нь *“уул уурхай болон боловсруулах үйлдвэрийг дэмжих дэд бүтцийн төслүүдэд санхүүжилтийн эх үүсвэрээс үл хамааран хөрөнгө оруулалтыг болон дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх үндэсний боловсон хүчнийг бэлтгэн чадвах жуулахад орших”* юм¹

3. Төслийн хүрээнд Шүрэнгийн усан цахилгаан станцын төсөл (ШУЦС) болон Орхонгол дээр урсцын тохируулаг бүхий усан сан байгуулах (ОГУ) төсөл гэх хоёр дэд төслийн үнэлгээний судалгааг санхүүжүүлж байгаа ба эдгээр нь Монголын Сэлэнгэ мөрөн болон Оросын Холбооны улсын Дэлхийн өв болох Байгалнуурт нөхөхийн аргагүй байгаль орчин, нийгмийн нөлөөлөл үзүүлж болзошгүй гэж хүсэлт гаргагчид үзэж буй юм. Түүнчлэн, хүсэлт гаргагчид нь эдгээр дэд төслийг сонгосон байдалд эргэлзэж, эдгээрийн хил дамнасан болон хуримтлагдах нөлөөлөлтэй холбоотой санаа зовниж буйгаа илэрхийлэхийн зэрэгцээ зөвлөлдөх ба мэдээлэл түгээх ажлыг хангалттай хийгээгүй гэж гомдол мэдүүлсэн болно.

¹Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн хүрээнд Монгол олгох зээлийн баримт бичгийн үнэлгээ. Дэлхийн банк, 4 дүгээр сарын 7, 2015, хуудас 4.

4. Хороо уг хүсэлтийг 2015 оны 3 дугаар сарын 13-нд хүлээн авч бүртгээд, Захирлуудын Зөвлөл (“Зөвлөл”) болон Банкны Удирдлага (“Удирдлага”)-д мэдэгдсэн байна. 2015 оны 4 дүгээр сарын 21-нд Удирдлагын зүгээс Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ (БОНМХ) болон Ажлын даалгаврыг монгол хэлэнд нэгэнт орчуулсан байсан тул МИНИС төсөл нь зөвлөлдөх болон мэдээлэл түгээх шаардлагыг хангасан гэсэн хариуг ирүүлсэн байна. Монголын Засгийн газар болон Оросын Холбооны улсын засгийн газрынхоёр талт уулзалтаар дээрх хоёр дэд төслийг хэлэлцсэн бөгөөд “Оролцогч талуудын зүгээс уг хоёр дэд төслийн талаар тавьж байгаа үндэслэл бүхий санаа зовнил болон асуудлуудыг чухамдаа Хүлээн авагч талд Үнэлгээний цогц судалгаа хийхэд нь дэмжлэг үзүүлэх замаар судлах зорилготой байгаа” гэдгээ Удирдлага илэрхийлсэн². Зөвлөлдөх ба мэдээлэл түгээх ажил болон Үнэлгээний судалгааг Банкны бодлого, журмын дагуу хичээнгүйлэн хийлгэнэ³ гэж Удирдлагын зүгээс нэмж мэдэгдсэн байна.

5. Хороо нь Монгол болон Орос улсад ажилласны дараа анхны тайлан ба зөвлөмжийг 2015 оны 7 дугаар сарын 2-нд 33-д хүргүүлсэн ба үүгээр Хүсэлт нь техникийн шалгуурыг хангасан гэдгийг баталгаажуулсан.⁴ Хороо нь үйл ажиллагааныхаа журмын дагуу төсөл болон хүсэлтэд дурдагдсан боломжит хор уршиг хооронд үндэслэл бүхий уялдаа холбоо байгааг тогтоосон. Хүсэлтийн хариуд Удирдлагын зүгээс өгсөн үүрэг амлалт нь хүсэлт гаргагчдын гаргаж тавьсан асуудлыг шийдвэрлэх, бүх оролцогч талыг хамруулан үр дүнтэй зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, тэр дундаа ОХУ-д зохион байгуулах явдлыг хангахтай холбогдуулан шаардлагатай залруулах арга хэмжээ авах өргөн боломжоор хангасан гэж Хорооноос үзсэн. Ийнхүү хийсэн ажиглалтдаа тулгуурлан Хороо нь Банкны үйлдэл, эс үйлдэлд хяналт тавих шаардлагатай эсэх талаар зөвлөмж гаргахаа нэг жилээр хойшлуулсан болно. Зөвлөл 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдөр Хорооны зөвлөмжийг баталсан.

6. 2016 оны 7 дугаар сарын 6-нд Хороо хоёрдох тайлан ба зөвлөмжийг 33-д хүргүүлсэн.⁵ Хэдийгээр ахиц гарч байгаа ч гэсэн Хүсэлт гаргагчдын зүгээс тавьсан хэд хэдэн асуудлуудыг шийдвэрлэн хэрэгжүүлэхэд цаг хугацаа шаардагдаж байгааг Хороо тэмдэглэсэн. Тухайлбал, Оросын нутагт хэлэлцүүлэг хийхийн тулд хоёр орон хоёр талт хэлэлцээр хийж, албан ёсны тохиролцоонд хүрэх шаардлагатай байсан. Хороо нь Удирдлагын арга хэмжээний

²Монголын уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл, Уул уурхайн дэд бүтцийг дэмжих төсөл-нэмэлт санхүүжилт төслийн Хяналтын хорооны хүсэлтэд Удирдлагын өгсөн хариу. Дэлхийн банк, 2015 оны 4 дүгээр сарын 21, хуудас.29-30.

³Ibid. х.30.

⁴Монголд Хороо ажиллуулах хүсэлтийн Тайлан болон Зөвлөмж: Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл болон Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл Нэмэлт санхүүжилт, Хороо, 2015 оны 7 дугаар сарын 2.

⁵Монголд Хороо ажиллуулах хүсэлтийн Хоёрдох Тайлан болон Зөвлөмж: Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл болон Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл Нэмэлт санхүүжилт, Хороо, 2016 оны 7 дугаар сарын 6.

хэрэгжилтэд үнэлэхийн тулд тодорхой ахиц дэвшил гартал хүлээх шаардлагатайг дурдсан болно. Иймд, Хороо хугацааг дахин хойшлуулахыг санал болгож, улмаар Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ)-нийхамрах хүрээ ба ахиц дэвшил, мөн Орос, Монгол улсад явагдах хэлэлцүүлгийн үйл явцын чанарт үнэлгээ хийн нэг жилийн хугацаанд 33-д дахин тайлагнахыг амласан. Хорооны зөвлөмжийг 2016 оны 7 дугаар сарын 20-нд 33 баталсан.

7. Төслийн хэрэгжилтийн өнөөгийн байдал. Удирдлагын зүгээс дуусгахад 24 сарын хугацаа шаардагдана гэх ШУЦС болон ОГУ-ны техникийн судалгааны ажлыг дуусгахад ахиц гаргах боломж олгох үүднээс Банк 2016 оны 7 дугаар сарын 27-нд төслийн хугацааг 2017 оны 9 сарын 30 хүртэл нэг жилээр сунгах шийдвэрийг баталсан. Удирдлага нь 2017 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Шинэчилсэн тэмдэглэлд (Хавсралт 1) шинээр баталсан сунгалт нь бүс нутгийн байгаль орчны үнэлгээ (БНБОУ), магадгүй түүнийг даган гарах БОННУ болон техник, эдийн засгийн үнэлгээ (ТЭЗҮ)-г хийж дуусгах хугацаа олгож болох юм гэж тэмдэглэсэн. Төслийн хугацааг шинэчлэн сунгах шийдвэрийг 2017 оны 6-7 дугаар сард Монголд хийсэн нэмэлт хэлэлцүүлгийн дараа эцэслэн гаргах боломжтой. 2017 оны 6 дугаар сард Монголд ажиллах үед Монголын Засгийн газар төслийн хугацааг дахин сунгах хүсэлтийг Банкинд гаргана гэж Хороонд мэдэгдсэн.

Б. Хорооны хоёрдох тайлангаас хойших үеийн төслийн явц

8. Удирдлагын шинэчилсэн тэмдэглэл. Удирдлага нь Хороонд өөрийн гаргасан ахиц дэвшлийг мэдэгдэх үүднээс 6 дугаар сарын 2, 6 дугаар сарын 26-ны өдрийн (Хавсралт 2) мөн 2017 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн (Хавсралт 3) шинэчилсэн гурван тэмдэглэлийг ирүүлсэн. Тэдгээр тэмдэглэлүүдэд өнгөрсөн жилд хэлэлцүүлэг болон ажлын даалгаврын төслийг шинэчлэх чиглэлээр ихээхэн ахиц гарсан гэж Удирдлага цохон тэмдэглэсэн.

9. Орос Улсад хийсэн хэлэлцүүлэг. Төсөл удирдах нэгж (ТУН) нь 2017 оны 3 дугаар сараас 5 дугаар сарын хооронд Төслийн үзэл баримтлал ба ажлын даалгавруудын төслийг хэлэлцүүлэх үүднээс нийт 14 хэлэлцүүлгийг Орос улсад зохион байгуулсан гэж Удирдлагын зүгээс тайлбарласан ба үүнд Буриадад хийсэн 11 хэлэлцүүлэг, Эрхүү мужид хийсэн 3 хэлэлцүүлэг тус тус орж байгаа юм. Удирдлагын үзэж буйгаар хэлэлцүүлэгт орон нутгийн иргэд, ТББ-ууд болон орон нутгийн захиргааны төлөөлөл зэрэг нийт 1700 оролцогч талууд оролцсон.

10. ТУН-ийн ажилчид Дэлхийн банкны багийн нэг гишүүнтэй хамт Орос улсад хэлэлцүүлэг хийхээс нэг сарын өмнө очиж хэлэлцүүлгийн замын зураглалын талаар тохиролцох, орос хэлээр бэлтгэсэн материалуудыг олон нийтийн газруудад тараахаар очиж ажилласан гэж Удирдлага дурдсан. Тэдгээр тараасан материалуудад энгийн ойлгомжтой хэлбэрээр бэлтгэсэн төслийн танилцуулга орсон болно. ШУЦС болон ОГУ төслийн ажлын даалгаврууд, тэдгээрийн техникийн болон техникийн бус хураангуй, асуулт-хариултын баримт бичиг, Хөндлөнгийн мэргэжлийн баг (ХМБ)-ийн ажлын даалгавар гэх мэт хэлэлцүүлгийн материалыг орос, англи хэлээр МИНИС-ийн вебсайтад байршуулсан. Материалуудын орос орчуулгыг хянах, чанарын шаардлагыг хангах үүднээс Банк орос орчуулагч авч ажиллуулсан гэж Удирдлага тайлбарласан.

11. Хэлэлцүүлэг болохоос нэг сарын өмнө хэлэлцүүлэг болох газрыг талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ил болгож, орон нутгийн хэвлэл мэдээлэл болон засаг захиргааны байгууллагуудаар дамжуулан зарласан гэж Удирдлага онцолсон. Удирдлагын үзэж буйгаар хэлэлцүүлгийг “олон улсын сайн туршилага болон Дэлхийн банкны бодлогын шаардлагын дагуу зохион байгуулагдсан”⁶ байна. Хэлэлцүүлгийн үеэр орос, монгол хэлний орчуулгаар хангасан. Түүнээс гадна, уугуул иргэд (УИ)-эд өөрсдийн санал бодлоо илэрхийлэх боломж олгох үүднээс буриад хэлний орчуулгаар хангасан. Дэлхийн банкны төлөөлөл хэлэлцүүлэг бүрд ажиглагчаар оролцсон. Орос улсын хуулийн дагуу хэлэлцүүлгийн протоколыг бэлтгэж, хоёр улсын засгийн газар гарын үсэг зурсан. Хэлэлцүүлгийн үеэр Сэлэнгэ мөрний бэлчир болон Байгал нуурт үзүүлэх байгаль орчны сөрөг нөлөөлөл, эрчим хүчний эх үүсвэрийн бусад хувилбарыг авч үзэх хэрэгцээ шаардлага болон БОННУ, ТЭЗҮ боловсруулахаас өмнө БНБОУ-г бэлтгэх зэрэг асуудлууд тавигдаж байсан гэж Удирдлага тайлбарласан.

12. Монголд хийсэн хэлэлцүүлэг. Оролцогч талууд Монгол дахь хэлэлцүүлгийн чанарын талаар санаа зовниж буйгаа илэрхийлсэн тул Монгол улсын Засгийн газар олон улсын сайн туршилагад нийцсэн нэмэлт хэлэлцүүлэг зохион байгуулахаар тохиролцсон байсан гэж Удирдлага тэмдэглэсэн. Удирдлага 2017 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн Шинэчилсэн тэмдэглэлдээ 2017 оны 6 дугаар сарын 28-наас 7 дугаар сарын 3-ны хооронд зургаан аймаг, Улаанбаатар хотод нийт 19 хэлэлцүүлэг зохион байгуулсан гэж дурдсан. Хэлэлцүүлгээс хоёр долоо хоногийн өмнө холбогдох материалуудыг монгол хэлнээ бэлтгэн нутгийн удирдлагын байруудаар тарааж, мөн МИНИС-ийн вебсайтад байршуулсан. Зар мэдээг телевиз, радио болон сонин хэвлэлээр түгээсэн. Хэлэлцүүлэг 2017 оны 6 дугаар сарын 26-ний Ерөнхийлөгчийн сонгууль дараа болон хоёрдох санал хураалт 2017 оны 7 дугаар сарын 7-нд явагдахаар төлөвлөгдсөн үед болсон хэдий ч “орон нутгийн захиргааны зүгээс нэг хэлэлцүүлэг цуцалсныг эс тооцвол сонгууль хэлэлцүүлэгт ямар нэг ноцтой нөлөөлөл үзүүлээгүй”⁷ болохыг Удирдлагын зүгээс мэдэгдсэн.

13. Удирдлага нь зөвлөлдөх болоод мэдээлэл түгээх уг үйл ажиллагаа нь “Банкны бодлогын шаардлагыг бүрэн хангасан”⁸ гэж үзэж буй. Хэлэлцүүлэгт орон нутгийн албан хаагчид, ТББ болон хувийн хэвшлийн төлөөлөл, нөлөөлөлд өртөж болзошгүй орон нутгийн иргэд гэх мэт 1000 гаруй хүн оролцсон. “Хэлэлцүүлэгт ашигласан илтгэлүүдийг мэргэжлийн бус оролцогчдод зориулан бэлтгэж, илтгэлийн хэллэг болон нэр томъёог оролцогч бүх хүмүүст ойлгомжтой байх хэлбэрээр тавьж танилцуулсныг”⁹ Удирдлага цохон тэмдэглэсэн. Гол тавьсан асуудлуудад, хөрсний үржил шим, бэлчээр, түүхийн дурсгалт газрууд, зэрлэг ан амьтан болон ургамлын нөмрөг, усны чанарт үзүүлж болох нөлөөлөл болон нүүдлийн мал аж ахуй эрхлэлт, амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөлөл гэх зэрэг асуудал орж байсан. Зарим нэг оролцогч тал төслүүдийг эсэргүүцэж байхад зарим нь газар хөдлөлийн эрсдэл, уур амьсгалын өөрчлөлт болон усны түвшин зэрэг асуудалд санаа зовж буйгаа илэрхийлж байсан гэж Удирдлага тэмдэглэсэн.

⁶Хороонд хүргүүлсэн Менежментийн шинэчилсэн тэмдэглэл, 6 дугаар сарын 2, 2017 хуудас3

⁷Хороонд хүргүүлсэн Менежментийн шинэчилсэн тэмдэглэл, 7 дугаар сарын 7, 2017 хуудас4

⁸хуудас 3

⁹Өмнө нь дурдсан

Хэлэлцүүлэгт оролцогчид өөрсдийн нэмэлт санал бодлоо 2017 оны 7 дугаар сарын 17-ны дотор 14 хоногийн хугацаанд ирүүлж болох бөгөөд МИНИС 9 дүгээр сарын эхээр тавигдсан асуудлуудын хариу бүхий хүснэгтийг боловсруулж, нийтэд ил болгоно.

14. Хэлэлцүүлгийн мөрөөр авч байгаа арга хэмжээнүүд. Төсөл хэрэгжүүлэх нэгж нь хэлэлцүүлгийн үеэр гарсан хэд хэдэн саналыг хэрэгжүүлэхээр ажиллаж байгааг Удирдлага онцлон тэмдэглэсэн:

- -БНБОУ ба БОННУ: төсөл бүрд БОННУ боловсруулахын өмнө БНБОУ-г тусд нь боловсруулан бэлтгэхийг Монголын Засгийн газар зөвшөөрсөн байна. Хэлэлцүүлгийн үеэр гаргасан санал хүсэлтийг БНБОУ-ний ажлын даалгаварт тусгаж байгаа ба Монголд явуулсан хэлэлцүүлгийн үр дүнг хүлээн авсны дараа хариултын хүснэгтийг МИНИС-ийн вебсайтад байршуулах болно. БНБОУ нь ШУЦС болон ОГУ төслүүдийг хамрах ба уг бүс нутгийг хамарсан ерөнхий стратегийн хувилбаруудад чиглэгдэх юм. Энэ нь хөрөнгө оруулалт, технологийн бусад хувилбаруудын дүн шинжилгээнээс бүрдэх бөгөөд үүнд салхи, нарны болон усны эрчим хүчний бусад хувилбаруудыг авч үзэхээс гадна “төсөлгүй” сценари бас орно. БНБОУ-нд Монгол улсын Сэлэнгэ мөрний сав газарт хэрэгжиж болох төслүүдийнхуримтлагдах нөлөөллийн үнэлгээг мөн хамруулна. Монгол улсын Засгийн газар нь БНБОУ-ний төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулна. Удирдлага нь 2017 оны 8 дугаар сард бэлэн болох боломжтой ажлын даалгаврыг хянахад ТУН-ид дэмжлэг үзүүлнэ гэж дурдсан ба судалгааныг эрээнд 2018 онд гарын үсэг зурж, 2019 он гэхэд тайлангийн төсөл бэлэн болно гэж тооцоолж буй болно. БНБОУ-ний дараа ТЭЗҮ болон БОННУ-г нэгэн зэрэг харилцан уялдаатай бэлтгэнэ.
- Мэргэжлийн шинжээчдийн баг: МШБ нь Орос, Монголын мэргэжилтэн нартай зөвлөлдөж, БНБОУ гэх зэрэг судалгааны төслийг хянан үзэж, улмаар нарийвчилсан БОННУ болон ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлэх эсэх талаар зөвлөмж гаргана.

15. Санал гомдол

Нөлөөлөлд өртөж болзошгүй оролцогч талуудаас санал гомдол хүлээн авах, санал гомдлыг шийдвэрлэх түргэн шуурхай арга хэмжээ авах, ирж буй санал гомдолд мониторинг хийж, тайлагнах үүднээс гомдол барагдуулах механизм (ГБМ)-ыг 2016 оны 4 МИНИС төсөл хэрэгжүүлж эхэлсэн гэж Удирдлага тэмдэглэсэн. ГБМ-ын хүрээнд хүлээн авсан гомдлын талаар хоёр сар тутамд тайлан бэлтгэж, вебсайтад байршуулж байна. Анхны тайланг МИНИС-ийн вебсайтад байршуулсан ба Банкнаас хянаж үзсэний дараа хоёрдох тайланг нийтлэх болно.

16. ГБМ-ын хүрээнд 2016 оны 4 сараас 2017 оны 11 дүгээр сарын хооронд 10 гомдол, мэдээлэл авах нэг хүсэлт хүлээн авсан. Эдгээр нь Монголд зохион байгуулж байгаа хэлэлцүүлгийн чанар, МИНИС-ийн вебсайтын чанар, өмнөх хэлэлцүүлгийн тайлан болон урьдчилсан ТЭЗҮ-ий судалгааг нийтэд ил болгоогүй, Оросын Кабанскид болсон нийтийн хэлэлцүүлгийн үеэрх асуудлуудад хариу хангалттай өгөөгүй, тараасан мэдээллийн материалуудын чанар муу мөн ГБМ-д санал гомдлыг бүртгэхгүй байгаа талаар хөндсөн байсан. 2017 оны 6 дугаар сарын 2-ны

Удирдлагын Шинэчилсэн тэмдэглэлд дурдсанаар хоёроос бусад гомдлыг хянан үзэж, зохих хариу арга хэмжээг авсан байна. Санал гомдлын мөрөөр ТУН зүгээс техникийн бус мэдээллийн материалыг сайжруулан, нарийвчлан заасан мэдээлэл түгээх протоколын дагуу нэмэлт хэлэлцүүлэг зохион байгуулж байгаа ба (1) МИНИС-ийн вебсайтыг сайжруулсан; (2) өмнөх хэлэлцүүлгийн бүх тайланг нийтэд ил болгосон; (3) урьдчилсан ТЭЗҮ-г нийтэд ил болгосон; мөн (4) Кабанскийн нийтийн хэлэлцүүлгийн үеэр тавигдсан асуудлуудад хариу бэлтгэсэн гэж Удирдлага мэдэгдсэн.

В. Хорооны томилгоот ажил ба ажиглалтууд

17. Хороо өөрийн хоёрдох тайлан ба зөвлөмжид, хяналт шалгалт явуулахыг санал болгох эсэх шийдвэр гаргах хугацааг нэг жилээр хойшлуулах санал дэвшүүлсэн ба (1) хэлэлцүүлгийн явцын чанар, (2) БОННУ-ний ахиц дэвшил ба хамрах хүрээг үнэлсний дараа өөрийн зөвлөмжийг гаргах санал тавьсан. Энэхүү хоёр асуудлаарх Хорооны хийсэн ажиглалтыг доорх хэсэгт өгүүлсэн болно.

18. Хяналтын хорооны гишүүн Зейнаб Элбакри болон үйл ажиллагааны мэргэжилтэн Тамара Милстажн 2017 оны 6 дугаар сарын 6-10-ны өдрүүдэд ОХУ-ын Улаан-Үд болон Эрхүүд очиж ажилласан. Хорооны дарга Гонзало Кастро де ла Мата 2017 оны 6 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд Монгол Улсын Улаанбаатарт хотноо тэдэнтэй хамт ажилласан. Хорооны гишүүд Орост ажиллах хугацаандаа хүсэлт гаргагчид болон Оросын Буриад, Эрхүү мужаас хэлэлцүүлэгт оролцсон нөлөөлөлд өртөж болзошгүй бусад хүмүүстэй уулзаж ярилцсан. Мөн Оросын Шинжлэх ухааны академийн Сэлэнгэ мөрний сав газар, Байгал нуурын гидрологи болон биологийн олон янз байдлын экспертүүд, Буриадын Бүгд найрамдах улсын Байгалийн нөөцийн яам болон Эрхүү мужийн төлөөлөгчид, Холбооны усны асуудал эрхэлсэн агентлагийн төлөөлөгчидтэй ч уулзсан. Түүнчлэн, Монголд ажилласан Хорооны гишүүд хүсэлт гаргагчид, нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд, Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газрын баг, Сангийн яам, Эрчим хүчний яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам болон МИНИС-ийн ТУН-тэй уулзсан. Өөрсдийн санаа бодлыг хуваалцан, мэдээлэл өгч, нарийн асуудлуудыг хөндсөн дээр дурдсан бүх хүмүүст Хороо талархал илэрхийлэхийн ялдамд Орос, Монгол дахь Дэлхийн банкны суурийн төлөөлөгчийн газрын ажилтнуудад ложистикийн туслалцаа үзүүлсэнд тусгайлан талархал илэрхийлж байна.

19. Хороо нь томилгоот ажлын хүрээнд цуглуулсан мэдээллээс гадна төслийг ойроос ажиглаж буй хүсэлт гаргагчидтай хийсэн тогтмол харилцаанаас үүдэлтэй мэдээлэл, Дэлхийн банк болон хүсэлт гаргагчдаас ирүүлсэн баримт бичгийг хянан үзэж, дүн шинжилгээг хийсэн болно. Хороо нь Олон улсын байгаль хамгаалах холбоонд байрлах Дэлхийн өвийн хөтөлбөртэй холбоотой ажиллаж, Байгал нууртай холбоотой Дэлхийн өвийн хорооны шийдвэр, зөвлөмжийг тогтмол авсаар ирсэн. Хорооны дүн шинжилгээ болон ажиглалтыг доор өгүүлсэн болно.

20. Монгол улсын эрчим хүчний нөхцөл байдал. Монгол улсын ДНБ-ний өсөлт 2014 онд 7.9 хувь байсан бол 2016 онд 1.0 болж ихээхэн буурсан. Түүхий эдийн зах зээл тогтворжиж эхэлснээр

2018 онд уул уурхайн салбарт өсөлт эхлэх төлөвтэйбайгаа бөгөөд ДНБ-ний өсөлт нь 2018 онд 3.5 хувь болж, 2019 онд 3.7 хувьд хүрэх урьдчилсан таамаглал байна.¹⁰

21. Эрчим хүчний систем нь хоцрогдсон, хотжилт болон уул уурхайн салбараас үүдэлтэй эдийн засгийн өсөлтөөсүүдэн нэмэгдэж буй эрэлтийг хангаж чадахгүй байгаа тул Монгол улс цахилгаан хангамжийнүйлчилгээг найдвартай, тогтвортой хангажчадахгүй байна. Эл байдал нь эрчим хүчний импортыг нэмэгдүүлэхэд хүргэсэн. Цаашилбал цахилгаан дамжуулах сүлжээ нь хуучирч муудсан, үр ашиггүй байгаа учир цахилгааны ихээхэн алдагдал гарч байгаа бөгөөд зарим газруудад байнга цахилгаан тасарч байна. Хэдийгээр Монгол улс нар, салхины эрчим хүчний асар их нөөц, усны эрчим хүч ашиглах боломж өндөр боловч цахилгаан станцуудад нүүрсийг зонхилон ашиглаж, дотоодын эрчим хүчний зөвхөн 3 хувийг сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэж байна.¹¹

22. Банкны зүгээс олон санаачилгаар дамжуулан Монгол Улсын Засгийн газарт эрчим хүчний үр ашгийг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчний асар их нөөцийг ашиглах замаар эрчим хүчний салбарт тулгараад байгаа бэрхшээлийг даван туулахад чиглэсэн дэмжлэг үзүүлж, улмаар2030 он гэхэд эрчим хүч үйлдвэрлэлийн 30 хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангах үндэсний зорилгод хүрэхэд нь хувь нэмэр оруулж буй юм. Одоогийн эрчим хүчний системийн үр ашгийг сайжруулах, сэргээгдэх эрчим хүч болон усны эрчим хүч зэрэг бүхий л эх үүсвэрийг ашиглах замаар эрчим хүчний тогтвортой хангамжийг баталгаажуулах өргөн хүрээтэй стратегийн зорилтын хүрээнд нь МИНИС төслийг хэрэгжүүлж буй гэдгийг Хороо ойлгож байна.

23. Орос улсад хийсэн зөвлөлдөх уулзалтууд.Хороо Орос улсад ажиллах хугацаандаа Бүгд Найрамдах Буриад улс болон Оросын Эрхүү мужид явуулсан хэлэлцүүлэгт оролцсон олон төлөөлөл бүхий оролцогч талуудтай ярилцсан. Тэдгээрт нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд, засгийн газрын ажилтнууд, эрдэмтэн судлаачид орсон болно. Нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн төлөөлөлд“эртний сүсэгтэн”уугуул иргэдийн төлөөллүүд болон нэг уугуул иргэдийн бүлэг (Евенкүүд)-ийнтөлөөллүүд, мөн загасчид, малчид, фермерийн төлөөлөл болон аялал жуулчлалын салбарт ажиллагсад байсан. Түүнчлэн, Улаан-Үд болон Эрхүүд томоохон хэмжээний хоёр уулзалтыг засгийн газрын ажилтнууд зохион байгуулсан ба уг уулзалтад Сэлэнгэ мөрний сав газар болон Байгал нуурын чиглэлээр ажилладагolon тооны эрдэмтэд болон Орос, Монголын хамтарсан хилийн усны комиссын нэг төлөөлөгчоролцсон.

¹⁰Монголд үзүүлэх ОУХА-н зээлийн болон Эрчим хүчний салбарын хоёрдох төслийн уур амьсгалын өөрчлөлтийн сангийн грантын Төслийн мэдээлэлийн баримт бичиг, Дэлхийн банк, 2017 оны 1 дүгээр сарын26, хуудас 2

¹¹хуудас.3.

24. Нийт 14 хэлэлцүүлэг зохионбайгуулж, 1700 оролцогч нар оролцсоныг Хороо баталгаажуулсан. Орос болон Монголын холбогдох эрх бүхий байгууллагуудын хамтын хүчин чармайлтаар хэлэлцүүлгийг сайн зохион байгуулалттай явуулсан гэдэгт ерөнхийдөө санал нэг байв. Буриадын засгийн газартай хэлэлцүүлгийг зохион байгуулах суурин газар болон ложистикийн асуудлаар урт удаан хугацаанд албан бусаар харилцан тохиролцсон тухай ХороондТУН мэдээлсэн. Хороотой уулзаж ярилцсан хүмүүсийн сэтгэгдлийг үзвэл хэлэлцүүлгийг Дэлхийн банкнаас тогтоосон стандарт болон Оросын хууль тогтоомжийн шаардлагыг мөрдөн зохион байгуулсан. Уг стандартад тухайн хэлэлцүүлэг болохоос 30 хоногийн өмнө олон нийтэд зарлан мэдээлж, холбогдох баримт бичгийг олон нийтийн газруудаар тараах ба хэлэлцүүлэг болсноос хойш 30 хоногийн хугацаанд санал сэтгэгдлийг хүлээн авах шаардлагатай байсан. Түүнчлэн уг стандартын дагуу хэлэлцүүлгийн агуулгыг хураангуйлсан протокол бэлтгэж, хоёр тал гарын үсэг зурахыг шаарддаг.

25. Хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, вебсайтуудаар болон орон нутгийн байгууллагууд өргөн сурталчилсан болохыг Хороо орон нутагт ажиллах үеэрээ баталгаажуулсан. Зарим тохиолдолд хэлэлцүүлэгт оролцогсдыг орон нутгийн засаг захиргаа унаа хөсгөөр хангаж байсан. Хэлэлцүүлгийн ирц сайн байсан, нэг удаагийн хэлэлцүүлэгт 60-300 хүн оролцож байсан ба оролцогчдын бараг тэн хагас нь эмэгтэйчүүд байсан тухай Хороо олж мэдсэн. Харин баримт бичгүүдийг авах боломж бага газруудад байршуулсан эсвэл зөвхөн хэлэлцүүлгийн үеэр тараагдаж байсан нь баримт бичгүүдтэй нухацтай танилцаж, холбогдох асуултуудаа бэлтгэх хугацаа хомс байсан гэж зарим иргэд гомдолсон. Хэлэлцүүлэгт зориулан тараасан гэж ТУН-ээс Хороонд тайлбарлаж буй 11 баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 4-р харуулсан болно.

26. Хорооныуулзаж ярилцсан оролцогч талууд хэлэлцүүлгийн явцын сул тал нь мэргэжлийн болон техникийн үг хэллэгийг хэрэглэж байсан тул хэлэлцүүлгийн зорилго, мессежийг ойлгоход хүндрэл учруулж байсан болохыг цохон тэмдэглэсэн. Олон оролцогчид усан цахилгаан станцууд (УЦС)-ын бодит нөлөөллийн талаар асууж, хариулт авна гэж бодож байсан боловч харин хэлэлцүүлгийн зорилго нь үнэлгээгээр ямар нөлөөллийг судлах талаар шийдвэр гаргах үүднээс ажлын даалгаврыг хэлэлцэхэд оршиж байсан. Тийм учраас, олон оролцогч талууд ямар нэг хэмжээгээр урам хугарсан байдалтай хэлэлцүүлгээс гарсан байна.

27. Хороотой уулзаж ярилцсан хүмүүс тухайн төсөл нь уул уурхайн салбарт гэхээс илүү Монголын хүн амдасар шаардлагатай байгаа усан болон эрчим хүчний хангамжийг сайжруулах зорилготой гэж танилцуулсан ба далангаас үүдэх магадлалтай сөрөг нөлөөллийг санаатайгаар бүдгэрүүлж байсан, түүнчлэн асууж тодруулах цаг хугацаа хязгаарлагдмал байсан гэх гол асуудлуудыг хөндсөн болно. Оролцогч талуудын зүгээс тавьж байсан тодорхой асуудлуудын дотор зонхилох нь УЦС барьж байгуулснаар иргэдийн амьдралын хэв маяг, амьжиргаанд үзүүлэх нөлөөлөл, тур дундаа Байгал нуурын эрдэнэ болсон омуль загасны түрсээ шахдаг орчинд үзүүлэх хор хохирлын талаар байсан. Байгаль орчны доройтол Байгал нуурт хэдийнээ сөрөг нөлөө үзүүлж эхлээд байгаа ба санал болгож буй Шүрэнгийн УСЦ нь байдлыг улам дордуулах болно гэсэн санааг олон хүн илэрхийлж байв. Мал аж ахуй эрхэлдэг оролцогч талуудын хувьд усны хомсдол, түүний бэлчээрт үзүүлэх нөлөөллийн талаар зовниж байв. Евенк уугуул иргэдийн

хувьд, загас агнуурт үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар зовниж байна. Оролцогч талуудын зүгээс тавьж байсан асуудлуудын заримыг Оросын хэвлэл мэдээлэлд нийтэлсэн байсан.¹²

28. Байгал нуурын талаар асар их судалгааны ажил хийгдэж, өгөгдлүүдийг олон жилийн турш цуглуулж байгаа бөгөөд Байгал нуур болон Сэлэнгэ мөрний хувьд гидрологийн хүчтэй өөрчлөлт явагдаж байгаа ба 2014 онд усны түвшин сүүлийн 100 жилийн хамгийн доод түвшинд хүрч буусан нь Байгал нуур усны хомсдолд өртөх магадлалтайг Улаан-Үд болон Эрхүүгийн эрдэмтэн судлаачид тайлбарлаж байсан. Түүнээс гадна, усны чанар, температур болон гидрологийн нөлөөлөл үүсч болзошгүйд санаа зовж байгаагаа илэрхийлж байв.

29. Үүн шиг хил дамнасан нөхцөлд хэлэлцүүлэг зохион байгуулах нь ээдрээтэй бөгөөд эмзэг асуудал болохыг Хороо хүлээн зөвшөөрч байна. Орос улсад зохион байгуулсан хэлэлцүүлгийн хувьд Оросын оролцогч талуудын дуу хоолойг сонсоход чиглэгдсэн томоохон хэмжээний, сайшаахуйц ажил болсон бөгөөд Монгол, Оросын эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааны ачаар саадгүй явагдсан гэж Хороо үндсэндээ үзэж байна. Буриадын Байгалийн нөөцийн яаманд зохион байгуулсан уулзалт энэхүү байр суурийг бататгаж өгсөн ба уулзалтын үеэр Оросын ахлах албан тушаалтнууд хэлэлцүүлгийг Орос улсын нийтийн сонсголын тухай хууль тогтоомжийн дагуу явуулж, тавьсан зорилгоо хангасан гэдгийг онцолсон. Буриадад зохион байгуулсан нийтийн хэлэлцүүлгийн дараа, 2017 оны 3 дугаар сарын 31-нд Орос, Монголын албаны хүмүүсийн гарын үсэг зурсан протоколтой Хороо танилцаж, зөвлөлдөх уулзалт нь Оросын хууль тогтоомж болон Дэлхийн банкны шаардлагын дагуу зохион байгуулагдаж явагдсаныг баталгаажуулсан.

30. Хэлэлцүүлэг нь хүртээмжтэй, холбогдох баримт бичгүүдийг түгээн тараасан гэж Хороо дүгнэж байна. Уулзалтад нөлөөлөлд өртөж болзошгүй хүмүүсийн төлөөллийг харьцангуй сайн хангаж байгаа гэж үзэж болох олон төрлийн оролцогч талууд оролцсон байна. Уг уулзалтууд нь Төслийн талаар мэдлэг, мэдээллийг сайжруулахаас гадна дээр дурдсанчлан ажлын даалгаварт нөлөөлөх ихээхэн санал хүсэлт ирэхэд хүргэсэн. МИНИС төсөл тэдгээр саналуудыг ажлын даалгавар хянах явцдаа анхааралдаа авах үүрэг хүлээсэн гэж Хороо ойлгож байна. Хоёр талын гарын үсэг зурсан протоколд ТУН нь Оросын талын нэгтгэсэн саналыг авснаас хойш 60 хоногийн дотор саналын хүснэгтийг нийтэд ил болгох үүрэг амлалт авсан. Буриадад зохион байгуулсан хэлэлцүүлгийн үр дүнг МИНИС-ийн вебсайтад орос, англи хэлээр байршуулсан байгаа болно.¹³

¹²Хороо видео бичлэг болон орон нутгийн хэвлэлд нийтлэгдсэн материалуудтай танилцсан, үүнд Аригус телевиз \Улаан Үд\, Номер Үдийн сонин \Улаан Үд\, МК Улаан Үдийн сонин, Телеформ Мэдээллийн агентлаг \Эрхүү\, Восток-телеинформ мэдээллийн агентлаг \Улаан Үд,\” ФедералПресс” \Москва\, Эрхүүгийн долоо хоногийн аргумент сонин орж байгаа болно.

¹³<http://www.minis.mn/en/2017> вебсайтад байршуулсан

31. Үүний зэрэгцээ дээр өгүүлсэнчлэн Оросын оролцогч талууд зарим нэг дутагдлын талаар ярьж байсныг цаашид зохион байгуулах хэлэлцүүлэгт сургамж болгон анхаарах нь зүйтэй. Тодруулбал, хэлэлцүүлгийн зорилгыг илүү тодорхой мэдэгдэх, өөрөөр хэлбэл хэлэлцүүлэг нь Төслийн нөлөөллийн талаарх эцсийн хэлэлцүүлэг биш харин судалгааны ажлын даалгавартөөрчлөлт хийх үүднээс үнэлгээний хүрээнд ямар нөлөөллийг судлуулах талаарх хэлэлцүүлэг болохыг тодорхой мэдээлэх нь зүйтэй.

32. Монголд зохион байгуулсан хэлэлцүүлэг.Хэдийгээр хэлэлцүүлгийг Монголд 2016 оны 6-7 дугаар сард зохион байгуулсан ч гэсэн Орос болон Монголд зохион байгуулсан хэлэлцүүлэг нь ижил баримт бичгүүдэд тулгуурласан байх нөхцөлийг хангах үүднээс хоёрдох шатных хэлэлцүүлгийг зохион байгуулах саналыг МИНИС хүлээн авсан. Тэдгээр хэлэлцүүлгийг 2017 оны 6 дугаар сарын 28-наас 7 дугаар сарын 3-ны хооронд зохион байгуулахаар төвлөсөн байсан ба Хорооны томилгоот ажлын хугацаатай давхцаагүй болно. Хэлэлцүүлгийн бэлтгэл ажлын хүрээнд нутгийн удирдлагуудтай хамтран ажиллаж, холбогдох мэдээллийг нутгийн удирдлага болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан түгээж байгаа гэж МИНИС-ийн ажилтан Хороонд мэдэгдсэн. Нийт 19 зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, 1000 гаруй оролцогч талууд оролцсон гэх мэдээллийг Удирдлагын зүгээс Хороонд өгсөн.

33. ШУЦС болон ОГУ төслүүдийг хэрэгжүүлэхээр зэхэж буй газруудтай ойр амьдардаг, нөлөөлөлд өртөж болохуйц хэсэг бүлэг иргэдтэй Хороо уулзсан. Тэдний олонх нь УЦС-ууд баригдаж магадгүй гэдгийг мэдэж байгаа боловч тэдгээрийн нөлөөлөл, ялангуяа амьдралын хэв маяг, амьжиргаанд гарах өөрчлөлт, болзошгүй нүүлгэн шилжүүлэлтийн талаар мэдээлэл өгөөгүй гэж мэдэгдсэн. Өмнөх хэлэлцүүлэг нь болзошгүй эрсдэл гэхээсээ илүүтэй төслийн үр ашигт илүү ач холбогдол өгч байсан ба хэлэлцүүлгийн илтгэл болон бусад материалыг техникийн хэллэг ашиглан боловсруулсан, санал бодлоо илэрхийлэх цаг хугацаа хомс байсан гэх дутагдлыг тэд онцолсон. Түүнчлэн, Монголд хол зам туулах шаардлагатай тул хэлэлцүүлэгт очиход хүндрэлтэй байдгийг тэмдэглэж байсан. Түүнээс гадна, хүсэлт гаргагчид Хороонд ирүүлсэн захидалдаа анхны хэлэлцүүлэгт оролцсон хүмүүсийн ихэнх нь нөлөөлөлд өртөж болох хүмүүс биш байсан гэж дурдсан.

34. Хорооны уулзаж ярилцсан хүмүүсийн олонх нь хэлэлцүүлгийг дахин зохион байгуулах гэж буй өдрүүдийг мэдэж байсан ч уулзалт болох газрын талаар тодорхой мэдээлэлгүй байсан. Зарим нэг нь хэлэлцүүлгийн баримт бичгүүдийг тарааж байгаа гэсэн мэдээлэлтэй байсан ч бүгдээрээ гардан авч чадаагүй байсан. Малчид өглөөдөө сааль болон бусад ажилтай завгүй байдгийн дээр хэлэлцүүлэгт цагтаа амжиж очихын тулд хол зам туулдаг тул хэлэлцүүлэг хийхээр сонгосон цаг тохиромжгүй байгааг зарим нутгийн иргэд хөндсөн. Өөр нэг анхаарал хандуулах асуудал бол хэлэлцүүлгийн илтгэлийн дараа асууж, санал бодлоо илэрхийлэх хангалттай хугацаа олгох шаардлагатай байна гэж дурдсан. Хэлэлцүүлгийн үеэр саналаа бичиж үлдээх дэвтрээр хангасан гэсэн мэдээллийг Хороо авсан боловч тэдгээрийг хэлэлцүүлгийн өдөр нь өгөөд буцаагаад авдаг гэж МИНИС-ийн ажилтнууд хэлж байсан. Оросын зөвлөлдөх уулзалтуудын үеэр ашигласан багц баримт бичгүүдийн монгол хэлдээрх хувилбарыг ашиглах болохыг МИНИС төсөл Хороонд мэдэгдсэн.

35. Хорооны томилгоот ажлын үеэр хоёр дахь удаагийн хэлэлцүүлгийнхэлүүлээгүй байсан тул Хороо нь Удирдлага, МИНИС төслийн баг болон нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн зарим төлөөлөлтэй хийсэн уулзалтын мэдээлэлд үндэслэн хэлэлцүүлгийнзөвхөн бэлтгэл үед үнэлгээ хийх боломжтой байсан. Хэлэлцүүлэг явуулах өдрийн талаар нутгийн удирдлага болон иргэдэд мэдээлэлж, холбогдох баримт бичгүүдийг тараах зэрэгт ихээхэн хүчин чармайлт гаргасан байгаа тул бэлтгэл ажлын хувьд хангалттай явагдаж байна гэж Хороо үзэж байна. Хорооны уулзаж ярилцсан оролцогч талуудын олонх нь хоёрдох удаагийнхэлэлцүүлэгт оролцох хүсэлтэй байгаагаа илэрхийлж байсан. Хэлэлцүүлгийн материалыг тухайн хэлэлцүүлэг болохоос хоёр долоо хоногийн өмнө холбогдох хүмүүст нь хүргэсэн гэж Хороо ойлгож байна. Хэлэлцүүлгийн дараа хоёр долоо хоногийн хугацаанд оролцогсод өөрсдийн нэмэлт санаа бодлыг аймаг¹⁴, сумын болон олон багийн төвүүдэд тараах санал хүсэлтийн дэвтэрт бичих бололцоотой гэсэн ойлголтыг Хороо авсан.

36. Мэдээллийн менежмент ба МИНИС-ийн вебсайт.Хүсэлт гаргагчдын зүгээс ТУН нь санал гомдолд түргэн шуурхай хариу өгөх чадвар мөхөс, холбогдох материалуудыг нийгэд ил болгох шаардлагыг хангаж чадахгүй байгаа талаар Хороонд олон тооны гомдол гаргаж байсан. Түүнчлэн МИНИС-ийн вебсайт нь хэрэглэгчдийн хувьд ээлтэй бус, ямар нэг мэдээлэл олж авах, тайлан илтгэлийн олон хувилбаруудыг хайж авахад хүндрэлтэй тулгардаг талаар тэд гомдол мэдүүлж байсан.

37. ТУН-тэй хийсэн ярилцлага болон вебсайттай танилцаж үзэхэд мэдээллийн менежмент болон навигацийн хувьд дорвитой ахиц гарсан байна гэсэн ойлголтыг Хороо авсан. Вебсайтад орос хэлний цэс нэмж оруулсан ба “хэлэлцүүлгийн төв”гэсэн хэсэгт бүх хэлэлцүүлгийн материалууд болон зөвлөлдөх уулзалтуудын мэдээллийг оруулсан байна. Өмнө нь явагдсан бүх хэлэлцүүлгийн тайлангуудыг вебсайтад байршуулсан ба хэлэлцүүлэг, оролцогч талуудын оролцоо болон харилцаа холбооны асуудалд дэмжлэг үзүүлэх олон улсын нийгмийн мэргэжилтэн авч ажиллуулах гэж байгаа талаар Удирдлага тайлбарлан ярьсан. Энэ нь төслийн багынханд үнэтэй хувь нэмэр болж, цаашид ТУН-ийн чадавхийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм.

38. БОННУ-ний ахиц дэвшил ба хамрах хүрээ. БОННУ-ний явц болон хамрах хүрээнд үнэлгээ хийх нь хяналт шалгалт шаардлагатай эсэх санал оруулах шийдвэр гаргахад харгалзах хүчин зүйлсийн нэг гэж Хороо хоёрдох тайлан ба зөвлөмждөө тодорхойлсон. Тиймээс,Хороо Хүсэлт гаргагчдаас Хороонд ирүүлсэн янз бүрийн захидал харилцаа болон оролцогч талуудаас хэлэлцүүлгийн үеэр тавьж байсан асуудлууд судалж, ажлын даалгаврын төслийг анхан шатны байдлаар хянаж үзсэн. Хорооны хүлээн авсан болон уулзалтын үеэр гарсан саналыг харвал

¹⁴Монгол нь засаг захиргааны 21 нэгж “аймагт” хуваагдана. Засаг захиргааны хоёрдох түвшингийн нэгж нь “Сум” ба гуравдах түвшингийн нэгж нь “баг”болно.

оролцогч талууд хоёр төслийн БОННУ болон ТЭЗҮ-г боловсруулахаас өмнө БНБОУ-г жичид нь бэлтгэхийг илүүд үзэж буйгаа илэрхийлсэн. Түүнээс гадна, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хийж, цаашид боломжит бусад хувилбаруудад дүн шинжилгээ хийх хэрэгцээ шаардлага байгааг цохон тэмдэглэж байсан.

39. Хэлэлцэж буй ажлын даалгаврын төсөл, нэн ялангуяа Монголын ДНБ-ний одоогийн өсөлт болон ирээдүйн төлөв, түүнтэй уялдах эрчим хүчний эрэлт хэрэгцээ зэрэг ньалдаатай мэдээлэлд үндэслэсэн гэж Хорооны уулзаж ярилцсан эрдэмтэд үзэж байна. Түүнчлэн, гол үзүүлэлт бүхий суурь мэдээлэл нэн ялангуяа Монголд хомс байдаг ба стратегийн шийдвэрийг хуучирсан мэдээлэлд үндэслэн гаргасаар байгаа гэж тэмдэглэв.

40. Түүнчлэн, хэлэлцүүлгийн агуулгатай холбогдсон асуудлаар Хороо болон МИНИС-т хэд хэдэн мэргэжлийн дүгнэлт хүргүүлсэн. Зарим экспертүүд суурь мэдээлэл тийм ч амар олдохгүй эсвэл талбай дээр тийм мэдээллийг түргэн хугацаанд цөөн тооны экспертүүдээр цуглуулах боломжгүй гэж үзэж байна. Тиймээс, Байгал нуурын сав газрын өнөөгийн бодит нөхцөлд үндэслэсэн суурь судалгаа болон үнэлгээ хийхэд шаардагдах цаг хугацаа болон хөрөнгө нөөцийн нарийвчилсан тооцоололд тулгуурлан БНБОУ-г боловсруулах нь зүйтэй гэж тэд үзэж буй юм. Судалгааг бэлтгэхэд Орос, Монголын эрдэмтэд хамтран ажиллах шаардлагатайг тэд цохон тэмдэглэж байсан.

41. Зарим экспертүүд ажлын даалгаврын төсөл нь логикийн тодорхой бүтэцгүйн дээр газар нутгийн онцлог, боломжит технологийн болон техникийн олон шийдлүүдийг харгалзан үзэлгүй бүдүүн баараг тооцоолол болон ерөнхий зөвлөмжид үндэслэн боловсруулсан гэж үзэж буй юм. Эрчим хүчний салбарыг оролцуулан боломжит өөр хувилбарын дүн шинжилгээг боловсронгуй болгох шаардлагатайг тэд цохон тэмдэглэж байсан. ОГУ төслийн хувьд, ажлын даалгавар нь ус татах янз бүрийн хувилбаруудад төвлөрсөн боловч Өмнийн говийн бүс нутагт гүний усыг ашиглах боломж эсвэл төсөл хэрэгжүүлэх газрыг өөрчлөх талаар үнэлгээ нэмж оруулах нь зүйтэй болохыг тэд цохон тэмдэглэж байв.

42. Ойн нөөц болон уугуул иргэдийн хамгааллын бодлогыг мөрдүүлэх аливаа алхам хийгээгүй талаар тэд асууж байсан. Газар хөдлөлтийн эрсдэл, загас агнуур болон гидрологи, экологи болон биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөлөл болон нөлөөллийг бууруулах холбогдох арга хэмжээг тодорхойлж чадаагүй сул байгааг тэд дурдаж байсан. Түүнчлэн, иргэдийн амьжиргаа болон амьдралын уламжлалт хэв маягт үзүүлэх нөлөөллийг зохих ёсоор тодорхойлж чадаагүй гэж тэд үзэж байна. Эхний удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулахын өмнө олон төрлийн оролцогч талууд, тэдгээртэй зохих ёсоор зөвлөлдөх арга замыг тодорхойлсон оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөг бэлтгэн гаргаагүй байсан бөгөөд одоогийн ажлын даалгаварт тусгаснаар ийм төлөвлөгөөг БНБОУ, БОННУ-тэй зэрэг боловсруулна гэж байгаа талаар санаа зовниж буйг Хороо сонссон.

43. Уулзалтуудын үеэр тодорхойлсон асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хэлэлцүүлэгт ашигласан ажлын даалгаврын төслийг хянан үзэж буй гэж Хороо ойлгож байна. Судалгааны дарааллын хувьд, 2017 оны 6 дугаар сарын 2-ний өдрийн Шинэчилсэн тэмдэглэлд Монгол улсын Засгийн

газар БНБОУ болон БОННУ-г салгах шийдвэр гаргасан гэж Удирдлага тайлбарласан. Энэ мэдээллийг 2017 оны 6 дугаар сарын 26-ний өдрийн Шинэчилсэн тэмдэглэлд дахин баталгаажуулсан ба “Оросын холбооны улсад зохион байгуулагдсан хэлэлцүүлэг болон Дэлхийн банкны зөвлөмжийг харгалзан үзээд Монгол улсын Засгийн газар БНБОУ болон БОННУ-г салгаж, БОННУ болон ТЭЗҮ боловсруулахаас өмнө БНБОУ-г жичид нь хийх нь зүйтэй гэсэн шийдвэр гаргаж байна. БОННУ болон ТЭЗҮ-г зөвхөн БНБОУ-ний үе шатанд тэнцсэн төслүүдийн хувьд хийх болно. Гэхдээ, энэхүү шийдвэрийг хэлэлцүүлэг хийх явц дууссаны дараа албан ёсоор зарлах болно¹⁵. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ нь БНБОУ-ний салшгүй хэсэг байх болно гэж Удирдлага нэмж мэдэгдсэн. Үүгээр Монгол улсын Засгийн газрын авч үзэж буй Шүрэн, Орхон болон бусад усан-техникийн төслүүд болон одоо байгаа болоод ирээдүйд Сэлэнгийн сав газарт байгаль орчин болоод нийгмийн стресс үзүүлэгч хүчин зүйлсийн ганцаарчилсан болон хуримтлагдах нөлөөллийг үнэлэх юм.

44. Судалгааны дараалал чухал хэдий ч асуудлын гол нь ерөнхий багц судалгааны хүрээнд зөв цагт, газар зүйн зохистой хүрээнд болзошгүй нийгэм болон байгаль орчны нөлөөллийн цар хүрээг үнэлэх, уг цар хүрээ нь Байгал нуурыг оруулаад уг сав газарт үүдэх нөлөөллийг хангалттай түвшинд цогцоор хамрах, мөн уг бүс нутагт төлөвлөсөн болон болзошгүй төслүүдийн хуримтлагдах нөлөөллийг зөв зохистой авч үзэх явдал юм. .

45. Ажлын даалгаварт тусгагдаагүй үлдсэн гэх асуудалтай холбоотой саналуудын хувьд, Орос дахь уугуул иргэдэд үзүүлэх нөлөөлөл, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний ялангуяа Монголын алслагдсан нүүдэлчин иргэдэд үзүүлэх нөлөөлөл гэх зэрэг болзошгүй нийгмийн нөлөөллийг үнэлэх шаардлагатай талаар ажлын даалгаварт тусгаагүй байгааг Хороо онцолж байна. Төслийг амжилттай хэрэгжүүлэхэд хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг сайн хийх нь чухал гэдгийг Хороо цохон тэмдэглэж байна. Монгол улсын Засгийн газар ажлын даалгаврыг хянаж засах явцдаа хэлэлцүүлгээс гарсан саналыг анхааралдаа авахад тууштай хандана гэдгийг Хороо тэмдэглэж байна. МИНИС-ийн ТУН-ид олон улсын нийгмийн мэргэжилтэн авч ажиллуулах нь түүний хэлэлцүүлэг зохион байгуулах чадварыг бэхжүүлж, нийгмийн болзошгүй нөлөөллийн хамрах хүрээг илүү сайн тодорхойлоход хүргэнэ гэж Хороо онцолж байна. Эцэст нь, судалгааны төслийг МШБхянан үзэж, ямар нэг орхигдсон асуудал байвал тухайн үед нь шийдвэрлэх болно гэж Хороо ойлгож байна.

46. Дэлхийн өвийн хорооны тайлан илтгэл. ДӨХХ-ны 41 дүгээр чуулган 2017 оны 7 дугаар сарын 2-12-ны өдрүүдэд Краков хотод хуралдсан ба Эгийн гол төсөл Байгал нуурын биологийн олон янз байдалд ямар нөлөөлөл үзүүлж болзошгүй талаар нэмэлт судалгаа хийх гэж байгаад Хорооны зүгээс Монгол улсад талархал илэрхийлсэн. Түүнчлэн ШУЦС болон Орхон голын төслийн талаарх мэдээллийг, БНБОУ болон БОННУ-ний ажлын даалгаврыг оролцуулан, Монголоос хүлээн авснаа тэмдэглэсэн. Орос болон Монгол улсад хандан “*хоёр улсын нутаг дэвсгэр дээрх одоогийн болон төлөвлөсөн төслүүдийг харгалзан үзэж усан цахилгаан станц, усны менежментийн ирээдүйд хэрэгжүүлэх аливаа төсөлд зориулж хил дамнасан НБОУ-г хамтран*

¹⁵Хороонд зориулсан Менежментийн шинэчилсэн тэмдэглэл, 6 сарын 26, 2017

хийхийг”¹⁶– Хорооноос хүсэж буйг давтан онцолсон. Хоёр улсад хандан “Шүрэнгийн усан цахилгаан станц болон Орхон голын төсөл гэх мэт усан цахилгаан станц болон усны менежментийн аливаа тодорхой төслийн БОННУ-г нарийвчлан боловсруулахдаа хил дамнасан НБОУ-ний үр дүнг удирдлага болгох нь зүйтэй”¹⁷ гэх хүсэлтийг хоёр оронд тавьсан болно. Байгаль орчны үнэлгээний ¹⁸талаар Дэлхийн өвийн хорооноос ирүүлсэн зөвлөмжийн тэмдэглэлд цохон тэмдэглэсэн байгаль орчны стратегийн үнэлгээний олон элементүүд нь төслийн БНБОУ-нд тусгагдах болно гэж Хороо ойлгож байна. Тодорхой нэг төслийн талаар шийдвэр гаргах, стратегийн түвшинд хувилбаруудын дүн шинжилгээ хийхээс өмнө бүс нутгийн хүрээнд үзүүлж болох хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх зэрэг нь тэдгээр элементүүдэд хамаарагдана.

47. Дүгнэлт. Энэхүү төсөл нь нарийн техникийн онцлогтой бөгөөд нөлөөллийн хувьд хил дамнасан тул нарийн төвөгтэй төсөл болохыг Хороо тэмдэглэж байна. Орос болон Монголын эрх бүхий байгууллагууд энэхүү төслийн нарийн эгзэгтэй байдлыг ойлгож байгаа бөгөөд хоёр орны иргэдийн эдийн засгийн эрмэлзлийг хангахын төлөө ажиллахын зэрэгцээ байгалийн баялаг, байгаль орчныг хамгаалах туйлын зорилгыг удирдлага болгон хамтран ажиллахын төлөө байгаагаа харуулсан. Асуудлыг судалж, хянан үзэх үүднээс Монгол, Оросын эрдэмтдийн хамтарсан хороог байгуулсан нь энэ чиглэлд эерэг алхмууд гарсан болохыг харуулж байгааг Хороо хүлээн зөвшөөрч байна.

48. Орос улсад зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлгийн чанарын тухайд, Орос, Монголын эрх бүхий байгууллагууд ихээхэн дэмжлэг үзүүлж, Дэлхийн банкны болоод Оросын сонсгол явуулах стандартыг даган мөрдөх чармайлт гаргаснаар томоохон цар хүрээ бүхий ихээхэн хүчин чармайлт шаардсан зохион байгуулалтын ажлыг амжуулсан болохыг Хороо хүлээн зөвшөөрч байна. Хорооны зүгээс дээр дурдсанчлан хэлэлцүүлгийн зарим дутагдалтай талуудыг онцолж буй бөгөөд тэдгээр нь цаашид зохион байгуулах хэлэлцүүлэгт анхаарч ажиллах үнэтэй сургамж болно гэж тэмдэглэж байна.

49. Тиймээс, Хороо нь Орост зохион байгуулагдсан хэлэлцүүлгийн чанарт сэтгэл хангалуун байгаа бөгөөд Удирдлагын зүгээс холбогдох оролцогч талуудаас тавьсан асуудлуудад түргэн шуурхай хариу өгч, зохих ёсоор тусгуулна гэх хүлээлттэй байна. Хэдийгээр Хороо Монголд ажиллах үед хэлэлцүүлгийг зохион байгуулаагүй байсан боловч хэлэлцүүлгийн бэлтгэл зохих түвшинд чанартай хийгдэж байсныг Хороо тэмдэглэж байна. Бэлтгэл ажлын хүрээнд МИНИС-ийн ТУН болон нутгийн удирдлага хичээнгүйлэн ажиллаж, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулж байгааг Хороо ажигласан.

50. МИНИС нь хэлэлцүүлгийг Орос болон Монголд зохион байгуулж, хүсэлт гаргагчдын тавьсан асуудлуудад цогц байдлаар хариу өгч ажиллах тал дээр хүчин чармайлт гарган ажиллаж байгааг

¹⁶WNC/17/41.COM/7B, Краков, 7-р сар 2017. Доорх вэбсайтнаас харна уу <http://whc.unesco.org/en/soc/3618>

¹⁷Өмнө нь дурдсан

¹⁸Доорх вэбсайтнаас харна уу

https://www.iucn.org/sites/dev/files/import/downloads/iucn_advice_note_environmental_assessment_18_11_13_iucn_template.pdf

Хороо сайшааж байна. Орос улсад зохион байгуулсан хэлэлцүүлэг болон Орос-Монголын эрдэмтдийн хамтарсан хороог байгуулсан ньхамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэх болон энэхүү төсөл шиг хил дамнасан төслүүдийг амжилтад хүргэх, тогтвортой байдлыг хангахад чухал алхам болж байна.

51. Төсөлд хяналт шалгалт хийх хүсэлт гаргасан нь нэн ялангуяа хил дамнасан асуудлын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх замаар төслийг эерэг чиглэлд оруулж, Орос болон Монгол улсын оролцогч талуудтай бодитой зөвлөгөөн хийх тал дээр илүү ач холбогдол авчирч, улмаар хийхээр зэхэж буй нөлөөллийн судалгаанд тэдгээрийн санаа зовж буй асуудлуудыг тусгах боломжийг нэмэгдүүлсэн болохыг Хороо тусгайлан тэмдэглэж байна. Эцэст нь, сүүлийн хоёр жил гаргасан хүчин чармайлт нь төслийг тойрсон олон ээдрээтэй асуудлуудыг зөв ойлгож, хэрэгжүүлэхтэй холбоотойМИНИС-ийн ТУН-ийн чадавхийг бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсныг Хороо тэмдэглэж байна.

Г. Зөвлөмж

52. Хороо ньолон нийтийн хэлэлцүүлгийн чанар болон БОННУ-ний хамрах хүрээ гэх энэхүү хоёр хүчин зүйлсийг сонгон хяналт шалгалт явуулах эсэх дээр зөвлөмж гаргахаар шийдсэн байсан ба эдгээрийг хянаж судалсан болно. Төсөл томоохон тохируулгахийж, нөлөөлөлд өртөж болзошгүй хүмүүстэйзөв зохистой зөвлөлдөхөд хүчин чармайлт гарган ажилласан байгаад Хороо сэтгэл хангалуун байна. Түүнчлэн, Удирдлагын зүгээс БНБОУ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, боломжит өөр хувилбаруудад дүн шинжилгээ гэх зэрэг олон төрлийн байгаль орчны үнэлгээний хэрэгслүүдийг нэвтрүүлэхийг эрмэлзэхийн зэрэгцээ хэлэлцүүлгээс гарсан саналыг шинэчилсэн ажлын удирдамжид тусгахаар тууштай ажиллаж байгааХороо тэмдэглэж байна.

53. Хүсэлт гаргагчдын тавьсан асуудалд хариу өгөх болон Орос, Монголын эрдэмтдийн хамтарсан хороо байгуулах чиглэлээр хүчин чармайлт гарган ажилласан зэргээс харахад МИНИС-ийнТУН-н чадавхи бэхжиж байгаа болохыг Хороо тэмдэглэхэд таатай байна. Түүнчлэн, Монгол улсын эрчим хүчний салбарын үр ашгийг нэмэгдүүлэх, эрчим хүчний эх үүсвэрийг бусад хувилбаруудыг эрэлхийлэхэд Банкны зүгээс дэмжлэг үзүүлж байгааг Хороо тэмдэглэж байна. Дээр дурдсан бүхий л алхмууд нь Удирдлагын зүгээс зөв чиглэлд явж, холбогдох журмыг даган ажиллах эрмэлзэлтэй байгааг нотолж байна. Тиймээс, Хороо нь 1999 оны тодруулгын 5-р зүйлд заасан *“ХяналтынХороо нь Банк холбогдох журмыг даган мөрдөж байгаа эсвэл даган мөрдөх эрмэлзэлтэй байгаа нотолгоо нь хангалттай эсэхийг бие даан дүгнэх ба уг дүгнэлтээ Захирлын зөвлөлд өргөн мэдүүлэх тайланд”* гэх заалтыг үндэслэн хяналт шалгалт хийхгүй байх зөвлөмжийг гаргаж байна.

54. Энэхүү зөвлөмжийг гаргахдаа, цаашид Удирдлага нь Хүсэлт гаргагчид болон нөлөөлөлд өртсөн иргэдтэй барьж байгаа холбоо харилцаагаа үргэлжлүүлж, өмнөх хэлэлцүүлгээс авсан сургамжуудыг цаашид зохиох хэлэлцүүлэгт тусгах, тодорхойлсон байгаль орчны үнэлгээний хэрэгслүүдийг хамтад нь хичээнгүйлэн хэрэгжүүлэх шаардлагатай гэжХороо цохон тэмдэглэж байна. Түүнчлэн, ДӨХ-ны гаргасан шийдвэрийг холбогдох ажлын даалгаврын аливаа нэмэлт өөрчлөлтөд тусгуулан ажиллахыг Удирдлагад зөвлөж байна.

55. Эцэст нь, Хороо нь энэхүү зөвлөмжийг гаргах үед илрээгүй нөхцөл байдал эсвэл шинэ нотолгоонд үндэслэн энэхүү зөвлөмжийг үл харгалзан ирээдүйд Хяналт шалгалт хийх хүсэлт тавих эрхтэй болохыг онцолж байна. Хэрэв 33-өөс энэхүү зөвлөмжийг санал нэгтгэй хүлээн авбал Хороо нь Удирдлага болон хүсэлт гаргагчдад зохих ёсоор мэдэгдэнэ.

ХАВСРАЛТ I

МОНГОЛ УЛС:

УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ

ДЭМЖИХ ТӨСӨЛ (P118109) БОЛОН ТҮҮНИЙ

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН (P145439)

ТУХАЙ ХЯНАЛТЫН ХОРООНД ИРҮҮЛСЭН

МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧИЛСЭН ТЭМДЭГЛЭЛ

2017 оны 6 дугаар сарын 2

МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧИЛСЭН ТЭМДЭГЛЭЛ

МОНГОЛ УЛСАД АЖИЛЛАСАН ХЯНАЛТЫН ХОРООНД:

УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ (P118109) БОЛОН УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ-НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ (P145439)

2017 оны 6 дугаар сарын 2

1. Энэхүү тэмдэглэлд Хорооны 2015 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 97875-MN тайлан илтгэлд дурдсан саналуудын мөрөөр хийсэн ажлыг хураангуйлан тусгав.
2. **Оршил:** Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих (МИНИС) төслийн зорилго нь уул уурхай болон боловсруулах үйлдвэрийг дэмжих дэд бүтцийн төслүүдэд санхүүжилтийн эх үүсвэрээс үл хамааран хөрөнгө оруулалтыг болон дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх үндэсний боловсон хүчнийг бэлтгэн чадвахуулахад оршино. Төсөл нь үндэсний хэмжээний төсөл бөгөөд зөвхөн техникийн туслалцааг санхүүжилнэ – өөрөөр хэлбэл судалгааны ажлууд хамрагдах ба үүнд төслийн техник эдийн засгийн үндэслэл болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон чадавхижуулах асуудал орно. Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын санхүүжилт нь төсөлд хамрагдахгүй болно. Хүсэлт гаргачдийн зүгээс хэд хэдэн дэд-төслийн талаар хянан үзэх хүсэлт гаргасан ба усан цахилгаан станцийн хоёр дэд-төслийн техник эдийн засгийн үндэслэл \ТЭЗҮ\ болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх ажлыг МИНИС-р санхүүжүүлэхээр тодорхойлсон. Тэдгээр нь Орос, Монголын хилийг дамнан урсах Сэлэнгэ мөрний сав газарт хамрагдах Шүрэнгийн усан цахилгаан станц \ШУЦС\ болон Орхон гол дээр урсацын тохируулга бүхий усан сан байгуулах \ОГУ\ хоёр төсөл болно. Түүнээс гадна, тэдгээр ШУЦС болон ОГУ нь Дэлхийн өвд хамрагдах Байгал нуур болон Сэлэнгэ мөрний бэлчир дэх Рамсарын ус намгархаг газарт нөлөөлж болзошгүй юм. Тийм учраас, Банкны үйл ажиллагааны бодлогод дэвшүүлсэн шаардлагыг бүрэн хангах үүднээс Орос болон Монголын талтай зохих ёсоор зөвлөлдөн хэлэлцэж, нухацтай хандах шаардлагатай юм. Төсөл нь графикийн дагуу 2017 оны 9 дүгээр сарын 30 гэхэд дуусах ёстой боловч Бүс нутгийн байгаль орчны үнэлгээг \БНБҮ\ хийж дуусгах болон дараа нь БОННУ болон ТЭЗҮ-ийн судалгааг БНБҮ-ний шаардлагыг хангахуйц түвшинд хийхийн тулд төслийг хэрэгжүүлэх хугацааг сунгаж болох юм. Төслийн хугацааг сунгах асуудлыг 2017 оны 6 дугаар сард Монголд хийхээр төлөвлөж байгаа нэмэлт хэлэлцүүлгийн дараа шийдвэрлэх болно.
3. Төрийн бус байгууллагууд \ТББ\ болон нөлөөлөлд өртөх иргэдийн зүгээс 2015 оны 2 дугаар сард ШБ-дХүсэлт ирүүлсэн. Тухайн Хүсэлтийг бүртгэн баталгаажуулах эсэхийг шалгаж үзээд, Банкны үйл ажиллагаанд нэг жилийн хугацаанд шалгалт хийх шаардлагатай эсэх талаар шийдвэр гаргахыг хойшлуулахаар шийдсэн; ийнхүү нэг жилээр хойшлуулсан хугацаа нь 2017 оны 6 дугаар сарын эцэс гэхэд дуусах юм.

4. ШБ өөрийн тайлан илтгэлдээ, \1\ Монгол болон Орос дахь нөлөөлөлд өртөх иргэдтэй зохих ёсоор зөвлөлдөн ярилцах шаардлагатай; \2\ Төслийн нөлөөлөлд хамааралтай Сэлэнгэ мөрөн, Рамсарын намагархаг газар болон Байгал нуурын өвөрмөц онцлог байдлыг тодорхойлох үүднээс БНБҮ болон БОННҮ-ний ажлын даалгаварыг \АД\ эргэн хянан үзэх шаардлагатай; \3\ судалгааны ажлыг зохих түвшинд хийхийн тулд хангалттай хугацаа болон хөрөнгөөр хангах; \4\ АД-т хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ \ХНҮ\ хийх асуудлыг оруулах шаардлагатай бөгөөд тэрхүү үнэлгээнд Сэлэнгэ мөрний сав газарт ирэх 20 жилд барих боломжтой гэж үзэж байгаа бүх усан цахилгаан станцын асуудлыг хамруулах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэсэн. Эдгээр зөвлөмж нь 2015 оны 4 дүгээр сард хийсэн ЮНЕСКО-н үнэлгээний ажлын дүгнэлттэй нийцэж байгаа болно.
5. **Явц байдал:** Менежментээс ШБ-т 2016 оны 5 дугаар сарын 17-нд хүргүүлсэн шинэчилсэн тэмдэглэлээс хойшхи хугацаанд хэдийгээр \1\ 2016 оны сонгуулийн үр дүнд улс төрийн хувьд өөрчлөлт гарсан; \2\ хэлэлцүүлгийн төлөвлөгөөг Оросын Засгийн газартай тохиролцоход ихээхэн хугацаа шаардсан; \3\ хэлэлцүүлгийн цар хүрээнээс шалтгаалан Дэлхийн Банкнаас \Москвагийн оффисыг оролцуулан\ нэмэлт хөрөнгө болон дэмжлэг шаардлагатай болсон ч хэлэлцүүлэг болон АД-ыг хянан нэмэлт өөрчлөлт оруулах талаар нэлээд ахиц дэвшил гарч өнөөдрийн нааштай амжилтад хүрсэн. Тэдгээрийг дор тодорхой танилцуулж байна.
6. **Оросын оролцогч талуудтай зөвлөлдсөн нь:** Төсөл хэрэгжүүлэх нэгж \ТХН\ оролцогч талуудтай үр дүнтэй харилцаж, тэдний санал гомдолд хариу өгч байх нөхцлөөр Банкны баг хангаж чадсан.
7. 2017 оны 3 сараас 5 сарын хооронд нийт 14 удаа Орос улсад хэлэлцүүлэг зохион байгуулсан. Буриадад 11, Эрхүү мужид 3 хэлэлцүүлэг хийсэн. Буриадад явуулсан хэлэлцүүлэгт 1300 гаруй оролцогч тал оролцсон ба Эрхүү мужийн хэлэлцүүлэгт орон нутгийн иргэд, ТББ-д, орон нутгийн захиргаа болон засгийн газрын төлөөлөл зэрэг 400 орчим хүмүүс оролцсон.
8. Оросын хууль тогтоомжийн дагуу, Буриад болон Эрхүү мужид болсон хэлэлцүүлгийн дараа оролцогч талууд нэмэлт санал сэтгэгдэлээ илэрхийлэх боломжоор хангах үүднээс хэлэлцүүлгийг 30 хоногийн хугацаанд нээлттэй байлгасан. Орос улсад хийсэн хэлэлцүүлэг 6 дугаар сарын 16-нд \Эрхүүд нүүр тулсан хэлэлцүүлэгээс хойш 30 хоног\ хаагдах юм.
9. Хэлэлцүүлгийн мэдээлэл болон хэлэлцүүлэг болох газрыг нэг сарын өмнө товлосон ба энэ нь Оросын хууль тогтоомжид нийцэж, харин хэлэлцүүлгийн талаар урьдчилан мэдэгдэх тухай Банкны сайн туршлагын хугацаанаас хэтэрсэн юм. Иргэдэд ойлгомжтой байх үүднээс техникийн хэллэгийг хялбар энгийн байдлаар бэлтгэсэн товхимолыг орос хэлээр бэлтгэн тараасан.
10. Хэлэлцүүлгийн замын зураглалыг тохиролцох болон хэлэлцүүлгийн материалыг Оросын товлосон олон нийтэд хүртээмжтэй газруудаар тараах үүднээс МИНИС ТХН хэлэлцүүлэг болохоос нэг сарын өмнө Оросд очиж Оросын талтай ажилласан. Ингэж ажиллахад ТХН-тэй Дэлхийн банкны баг хамтарч ажилласан.
11. МИНИС-н вэбсайтын “хэлэлцүүлгийн төв” хэсэгт хэлэлцүүлгийн материалыг орос, англи хэлээр бэлтгэн байршуулсан. Тэдгээр материалд: АД, АД-ын техникийн хураангуй, АД-ын техникийн бус хураангуй, экспертийн багийн АД \ЭБ\ болон төслийн асуулт, хариултын баримт бичиг орсон. Түүнээс гадна, оролцогч талуудад зориулсан төлөвлөж байгаа судалгааны техникийн бус хураангуй материалыг бэлтгэсэн ба материалуудын өндөр чанартай орос орчуулга дээр Банкны баг ажилласан. БНБҮ болон БОННҮ-ний АД-ын

төслийг редакторлох болон ТЭЗҮ-ийн АД-ыг орчуулахад Банкны Москва дахь Оффиссоор дамжуулан орос хэлний орчуулагчдийг Банкны төслийн баг авч ажиллуулсан. Орчуулгуудад зөв нэр томъёог хэрэглэсэн эсэх, орос хэл дээрхи хэлэлцүүлгүүдийн баримт бичгүүдийн уялдаа холбоо, бүрэн тусгасан эсэх болон АД-ууд, АД-ын хураангуй, техникийн бус хурангуйнууд болон бусад материалын орчуулгыг хянан тохоох зэргээр ТХН-д бүхий л дэмжлэг туслалцаа үзүүлдэг орос хэлтэй шинжээчийг авч ажилуулан төслийн багийг бэхжүүлсэн.

12. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон орон нутгийн засаг захиргаагаар дамжуулан Буриад, Эрхүү болон ойролцоох дүүргүүдийн иргэдийг хэлэлцүүлэгт урин оролцуулсан. Улаан-Үд болон Эрхүү дэх Оросын Байгалийн нөөц ба Байгаль орчны яамны албан вэбсайтад хэлэлцүүлгийн тухай мэдээллийг байршуулсан. ТХН болон Оросын албаны хүмүүстэй тохиролцсоны дагуу олон нийтэд хүртээмжтэй газрууд, номын сангуудаар тараасан.
13. Хэлэлцүүлгүүдийг олон улсын сайн туршлага болон Дэлхийн банкны журмын шаардлагын дагуу явуулсан. Орос, монгол хэлний орчуулгатай явагдсан. Орон нутгийн уугуул иргэдэд санал сэтгэгдэлээ илэрхийлэх боломж олгох үүднээс буриад хэлний орчуулга мөн хийгдсэн. Хэлэлцүүлгийн протоколыг хөтлөн баримтжуулан, Орос улсад мөрдөж байгаа зохицуулалтын шаардлагын дагуу Монгол, Оросын тал гарын үсэг зурсан. Хэлэлцүүлгийн явцыг ТХН тодорхой баримтжуулсан бөгөөд одоо хэлэлцүүлгийн явц болон агуулга дээр нарийвчлан ажиллаж байна. Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчөөр ахлуулсан Банкны баг бүх хэлэлцүүлэгт ажиглагчаар оролцсон.
14. Сэлэнгэ мөрөн болон түүний бэлчир, Байгал нуур, ЮНЕСКО-н дэлхийн өв газруудад үзүүлж болох байгаль орчны сөрөг нөлөөллийн асуудалд оролцогч талууд гол анхаарал хандуулж байсан. Оролцогч талууд сэргээгдэх эрчим хүч, цөмийн эрчим хүч, Оросоос импортлох эрчим хүчний хэмжээг нэмэгдүүлэх зэрэг эрчим хүчний өөр эх үүсвэрийн хувилбарыг судлаж үзэх шаардлагатай байгаа талаар хэлэлцсэн. Зарим оролцогч тал БОННУ болон ТЭЗҮ-н өмнө БНБҮ-г хийж, жич АД-р хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн санааг илэрхийлж байсан.
15. **Хэлэлцүүлгийн дараахь тохиргоонууд:** Оролцогч талуудын гаргасан хэд хэдэн саналуудыг ТХН хүлээн авч, тэдгээрийг хэрэгжүүлэх асуудлыг боловсруулж байна:

- *БНБҮ:* БНБҮ-н АД-т Оросын Холбооны улс болон өмнө нь Монгол улсад зохион явуулсан хэлэлцүүлэгүүдийн санал хүсэлтийг анхааралдаа авсан. Оролцогч талуудын гаргасан санал хүсэлтийн нэгдсэн матриц болон тэдгээр нь АД-т хэрхэн тусгагдсаныг Монголд нэмэлт хэлэлцүүлэг явуулсаны дараа МИНИС-н вэбсайтад байршуулна. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх БНБҮ нь ШУЦС болон ОГУ төслүүдийг хамрах ба бүс нутгийн стратегийн хувилбарууд болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтөд байгаль орчны асуудал хэрхэн тусгагдаж байгаад анхаарах болно. Мөн байгаль орчинд аль болох бага нөлөөлөл үзүүлэх салхины эрчим хүч, нарны эрчим хүч болон усны эрчим хүчний зэрэг хувилбаруудыг эрэлхийлж, хөрөнгө оруулалтын болон технологийн өөр эх үүсвэрүүдэд дүн шинжилгээ хийнэ. Энэхүү үнэлгээ нь “төслийн бус” хувилбарыг эрэлхийлэх ба өртөг зардал, үр ашгийг харгалзан үзсэний үндсэн дээр төслийг хэрэгжүүлэх эсэх талаар шийднэ. Оролцогч талуудын зөвлөмжийн дагуу БНБҮ нь Монголын Сэлэнгэ мөрний сав газарт хэрэгжүүлэх/төлөвлөж байгаа төслүүдийн

байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн нэгдсэн үнэлгээг хийнэ. 2017 оны 8 дугаар сард эцэслэн бэлэн болох БНБҮ-ний АД-ыг хэлэлцүүлэгүүдийн санал сэтгэгдэлд тулгуурлан хянан нэмэлт өөрчлөлт оруулахад МИНИС-н ТХН-д Дэлхийн банкны баг дэмжлэг үзүүлнэ. БННҮ-ний судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авалтыг 8 дугаар сарын эхээр \Монголд 7 дугаар сард амралт урт хугацаанд үргэлжилдэгийг харгалзан\ эхлүүлэх хэрэгтэй бөгөөд БНБҮ-ний судалгааны контрактад 18 оны мөчлөгийн 1 дүгээр улиралд гарын үсэг зурах болно. Энэ графикайн дагуу, БНБҮ-ний тайлан илтгэлийн төслийг 19 оны мөчлөгийн 2 дугаар улиралд хэлэлцүүлэгт бэлэн болгосон байна.

- *БОННУ*: МИНИС ТХН болон Засгийн газар Оросын оролцогч талуудын БНБҮ-г БОННУ-нээс жичид нь авч үзэх зөвлөмжийг 33-д оруулсан. БОННУ-г БНБҮ-ний дараа хэрэгжүүлэхээр эцэслэн шийдвэрлээд байна. БНБҮ-ний төслийг нийтийн хэлэлцүүлэг болон олон улсын экспертүүдийн дүгнэлт хийсний дараа БОННУ-д тусгана. Тийм учраас, БОННУ-ний АД-ыг БНБҮ-г хийж дууссаны дараа эцэслэх болно. Техникийн ТЭЗҮ –г боловсруулах асуудлыг БНБҮ-ний үр дүнтэй уялдуулна. ТЭЗҮ болон БОННУ-г харилцан уялдаатай байдлаар нэг зэрэг хэрэгжүүлэх шаардлагатай.
- *Экспертийн баг (ЭБ)*: олон улсын экспертүүдийн АД-н төслийг бэлтгэж, хэлэлцүүлэгт нээлттэй болгосон. ЭБ нь Орос болон Монголын мэрэгжилтнүүдтэй зөвлөлдөж, судалгааны явц байдал, чанарыг хянаж үзээдтайлан илтгэлийн төсөл бэлтгэнэ. БНБҮ-ний төсөлтэй танилцаад, БОННУ болон ТЭЗҮ-г нарийвчилан хийх шаардлага байгаа эсэх талаар зөвлөлтөгөө өгнө.

16. **Санал гомдол барагдуулах:** МИНИС санал гомдол хүлээн авч барагдуулах механизмыг \ГБМ\¹ 2016 оны 4 дүгээр сараас ажиллуулсан. СГМ –ын зорилго нь МИНИС-н оролцоо бүхий үйл ажиллагааны нөлөөлөлд бодитой хамаарал бүхий иргэд, оролцогч талуудыг товлон тогтоох, тэдний санал гомдлыг хүлээн авч бүртгээд, тэдгээр санал гомдлыг түргэн шуурхай барагдуулах болон хүлээн авсан санал гомдолд ил тод мониторинг хийх, санаа түгшээж байгаа асуудлуудыг илтгэн танилцуулахад оршино. МИНИС ТХН хүлээн авсан бүх санал гомдлыг бүртгэж, тухайн санал гомдол нь МИНИС-н үйл ажиллагаатай холбоотой эсэхийг тогтоож, ул мөрөөр шалгалт хийх эсвэл холбогдолгүй санал гомдол болохыг шийдвэрлэнэ. Хэрэв тухайн санал гомдолын дагуу шалгалт хийх бол ТХН үнэлгээ хийх, гомдол гаргагсадтай уулзан нөхцөл байдлыг шийдвэрлэх арга хэмжээний талаар зөвлөлдөн тохиролцоно. Гомдол гаргагч нь тухайн асуудлыг Дэлхийн банкны гомдол барагдуулах үйлчилгээ \ГБҮ\–нд хэзээ ч хандаж болох ба эсвэл асуудлыг ШБ-д өргөн мэдүүлж болно.

17. ГБМ хүлээн авсан гомдолын талаар илтгэлийг зургаан сар тутам бэлтгэн нийтэлнэ. Анхны илтгэл нь ажиллаж эхэлсэн үеэс \2016 оны 4 дүгээр сарын 16\ 2016 оны 11 дүгээр сарын 16-

¹ГБМ-н товхимолыг дараахь сайтаас авах: <http://www.minis.mn/en/minis-grievance-resolution-mechanism>

нийг хамарч байгаа ба МИНИС-н вэбсайтад байршуулсан². Энэ хугацаанд зургаан гомдол хүлээн авсан. Тэдгээрийн гуравыг Монголд үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын ТББ-ын сүлжээ, нэг гомдлыг Монголын иргэн, нэг гомдлыг үндэсний эрдэм шинжилгээний хүрээлэн, нэгийг усны асуудалтай холбоо бүхий холбооноос гаргасан байна \илтгэлд тэдгээр гомдлыг нэр усгүй тусгасан\.

18. Тэдгээр гомдол нь:

- Орхоны урсацын тохируулгын төсөл удааширч байгаа ба энэ нь байгаль орчны хэт сунжирч байгаа шаардлагагүй үнэлгээнээс болж байна гэж үзэж байгаа тухай гомдол (2016 оны 4 дүгээр сарын 2016);
- Багануурын нөлөөллийн үнэлгээний тайлан илтгэлийг боловсруулах хэлэлцүүлэгийн чанар ба Монголын оролцогч талуудыг татан оролцуулж байгаа тухай (2016 оны 4 дүгээр сарын 22);
- ШУЦС болон Орхоны урсацын тохируулгын судалгааны талаар Монголд хийсэн хэлэлцүүлэг болон тараасан материалын чанар (2016 оны 5 дугаар сарын 4);
- Алтайн Өвөр говийн голын сав газрын захиргааны захиалгат Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийн үнэлгээний үр дүнтэй холбогдол бүхий хоёр гомдол (2016 оны 7 дугаар сарын 8);
- ШУЦС болон Орхоны урсацын тохируулгын судалгааны асуудлаар Орос улсад зохион байгуулсан хэлэлцүүлэгийн үеэр урьдчилсан ТЭЗҮ-г танилцуулаагүй, мэдээллийн материалуудын чанар муу, хоорондоо уялдаа авцалдаагүй байсан тухай (2016 оны 9 дүгээр сарын 23).

19. Нийт зургаан гомдолд үнэлгээ хийж, арга хэмжээ авсанаар гуравыг нь барагдуулсан. Үлдсэн гурван гомдлын хувьд гомдлыг барагдуулахад цаг хугацаа шаардсан, ээдрээтэй асуудал \олонхи нь техникийн чанартай, өөр хоорондоо уялдаа холбоотой\ байсан ба явагдаж байгаа хэлэлцүүлэгийн явцтай уялдаж байсан. Тэдгээр гомдлыг барагдуулахын тулд авах арга хэмжээнийн хувьд гэвэл:

- Шүрэн болон Орхоны судалгааны асуудлаар Монгол болон Оросын Холбооны улсын оролцогч талуудтай нэмэлт хэлэлцүүлэг зохион байгуулах болон техникийн бус мэдээллийн өргөн хүрээтэй материал бэлтгэх, протоколуудтай танилцах, нөлөөлөлд бодитой хамаарал бүхий оролцогчталуудад илүү хүртээмжтэй хүрч ажиллах.

²http://storage.embersoft.mn/d1af1f/page/92/MINIS%20GRM%20Summary%20Report%20Eng_Final_Feb10%20last_JHhsaaSwGiQxgSD.pdf

- Монгол болон Оросын Холбооны улсад зохион байгуулсан хэлэлцүүлэгтэй холбоо бүхий тайлан илтгэлүүд, хариултууд болон бусад холбогдох материалуудыг эцэслэн нээлттэй болгох
- МИНИС-ын хэлэлцүүлэг төв вэбсайтын чанар болон навигацыг боловсронгуй болгох
- Олон улсын зөвлөхүүдээр МИНИС-н Багануурын ХНҮ-ний тайланд дүгнэлт болон хавсрага суддалгааг хийлгэх ба уг судалгааны асуудлаар нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах
- Тендерийн үр дүнг дахин нягтлан, давтан үнэлгээ хийх замаар шударга өрсөлдөөний зарчмыг хангах.

20. Хоёр дахь буюу 2016 оны 11 сараас 2017 оны 5 дугаар сарыг хамарсан зургаан сарын тайлангийн төслийг ТХН боловсруулаад байгаа ба одоо Банкны баг төсөл дээр ажиллаж байна. Банкны зүгээс тайлан илтгэлийн төслийн тухайд татгалзах зүйлгүй гэж үзвэл зургаан сар тутмын хоёрдох тайланг МИНИС-н вэбсайтад байршуулна.

21. МИНИС-н ТХН дэр дурдсан тайлангийн төслүүдийг эцэслэхээс гадна 2016 оны 11 дүгээр сарын 17-ноос 2017 оны 5 дугаар сарын 17-ны хооронд 7 санал гомдол, нэг мэдээлэл авах хүсэлтийг барагдуулсан. Түрүүчийн тайлангийн хугацаанд хүлээн авсан гурван санал гомдлыг дараагийн тайлангийн хугацаанд шилжүүлсэн. Одоогийн байдлаар, шинээр хүлээн авсан болон \шилжин ирсэн 8 санал гомдлын 6-д нь үнэлгээ хийж арга хэмжээ аваад байна. Энэ хугацаанд шинээр хүлээн авсан санал гомдолууд нь Орос, Монгол болон Буриадын ТББ-уудаас ирсэн ба дараахь асуудлуудыг хөндсөн:

- МИНИС-н вэбсайтын чанар болон хэрэглэгчид ээлтэй бус байгаа;
- Өмнө зохион байгуулагдсан хэлэлцүүлгүүдийн тайлан илтгэлийг нээлттэй болгох;
- МИНИС-н вэбсайтад байршуулсан Шүрэн болон Орхоны урьдчилсан ТЭЗҮ нийтэд хүртээмжтэй нээлттэй биш байгаа талаархи хоёр гомдол;
- Гомдол барагдуулах механизмд явуулсан санал гомдлыг бүрэн хамруулан бүртгэхгүй, хариу өгөхгүй байгаа;
- Буриадын Кабанск сууринд ШУЦС БНБҮ\БОННУ-ний АД-ын асуудлаар бие даан зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр гарсан санал сэтгэгдэлд хариу өгөхгүй байгаа \ДБ болон МИНИС ТХН эдгээрт оролцоогүй болно\;

- Орхон болон Шүрэнгийн БННУ\БОННУ-ний АД-н төсөлтэй холбогдуулан Орос улсад үйл ажиллагаа явуулдаг ТББ-н тавьсан санал сэтгэгдэл болон гомдолуудад хариу өгөхгүй байгаа;
- МИНИС-н дэд төсөлүүдтэй холбоо бүхий жендерийн стратеги, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний талаар мэдээлэл авах хүсэлт.

Эдгээрийн хариу болгон ТХН дараах арга хэмжээг авсан:

- Вэбсайтыг боловсронгуй болгосон;
- Өмнө зохион байгуулсан бүх хэлэлцүүлгийн тайлан илтгэлийг нээлттэй болгосон;
- Шүрэн болон Орхоны урьдчилсан ТЭЗҮ-г вэбсайтад байршуулсан;
- Кабанскад зохион байгуулсан бие даасан хэлэлцүүлгийн үеэр тавигдсан асуултуудын хариуг бэлтгэн нээлттэй болгосон;
- БННУ\БОННУ-ны АД-н төсөлтэй холбогдон гарсан санал сэтгэгдэлүүдэд өгөх хариуг бэлтгэн нээлттэй болгосон;
- Жендерийн стратеги болон нүүлгэн шилжүүлэх төслийн талаар мэдээлэл өгсөн.

ГБМ–н цахим шуудангийн техникийн бэрхшээлээс шалтгаалан хүлээн авсан нэг гомдолыг барагдуулаагүй боловч санал гомдол хүлээн авах, ил тод байдлыг хангах үүднээс хүлээн авсан санал гомдлын зургаан сар тутмын тайлан мэдээг байршуулах өргөн боломжтой болсон.

22. Дараагийн алхамууд: Монголд зохион байгуулагдсан хэлэлцүүлгүүд төслийн бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн ч оролцогч талууд хэлэлцүүлгийн чанарын асуудалд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлж байсан. Олон улсын сайн туршлагад тулгуурласан, оролцогч талуудын хамралтыг сайжруулсан нэмэлт хэлэлцүүлгүүд зохион байгуулахын ач холбогдолын талаар Монголын тал Дэлхийн банкны багтай харилцан тохиролцсон. Энэхүү шийдвэрийг 2017 оны 5 дугаар сарын 18-нд Эрхүү хотод зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр нийтэд зарлан мэдэгдсэн. 2017 оны 6 дугаар сарын 26-нд болох Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор 6 дугаард ямар нэг олон нийтийг хамарсан арга хэмжээ зохиохыг хязгаарласан ч МИНИС 6 дугаар сарын 28-наас 7 дугаар сарын 1-ний хооронд 18 хэлэлцүүлгийг (ШУЦС-аар 6, ОУТ-аар 8, мөн ШУСТ/ОУТ асуудлаар 3) зохион явуулахаар төлөвлөсөн. Хэлэлцүүлгийг дөрвөн баг \ШУЦС-р хоёр баг, ОУТ-оор хоёр баг\ зэрэг зохион байгуулахаар болсон. Хэлэлцүүлгүүдийг зохион байгуулахын тулд ТХН-н баг 8 дугаар сарын 5-6-ний өдрүүдэд хэлэлцүүлэг зохион явуулах газруудад очиж хэлэлцүүлгийн материалуудыг тарааж, орон нутгийн удирдлагатай зохион байгуулалтын асуудлаар тохиролцоно.

ХАВСРАЛТ II

МОНГОЛ УЛС:

УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ

ДЭМЖИХ ТӨСӨЛ (P118109) БОЛОН ТҮҮНИЙ

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН (P145439)

ТУХАЙ ХЯНАЛТЫН ХОРООНД ИРҮҮЛСЭН

МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧИЛСЭН ТЭМДЭГЛЭЛ

2017 оны 6 дугаар сарын 26

МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧИЛСЭН ТЭМДЭГЛЭЛ

МОНГОЛ УЛСАД АЖИЛЛАСАН ХОРООНД:

УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ (P118109) БОЛОН УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ-НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ (P145439)

2017 оны 6 дугаар сарын 26

1. Хорооноос 2017 оны 6 дугаар сарын 19-нд төсөлтэй холбогдсон асуудлаар ирүүлсэн асуултуудын хариуг энэхүү тэмдэглэлээр хүргүүлж байна.
2. **Монголын оролцогч талуудын санал сэтгэгдэлээ илэрхийлэх хугацаа.** 6 дугаар сарын 28-наас 7 дугаар сарын 3-ний хооронд Монголд нэмэлт хэлэлцүүлэг зохион байгуулах графиктай байна. Тэдгээр хэлэлцүүлгийг Банкны журмын дагуу зохион байгуулна. Хэлэлцүүлгийн материалыг хэлэлцүүлэгээс хоёр долоо хоногийн өмнө нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдэд хүргэнэ. Хэлэлцүүлгийн дараа хоёр долоо хоногийн хугацаанд нэмэлт санал сэтгэгдэл, асуултыг тэмдэглэлийн дэвтэрээр авах ба санал сэтгэгдлийн дэвтрийг холбогдох аймаг, сумын төвүүд болон хэд хэдэн багийн төвүүдэд нээн ажиллуулна.
3. **Бус нутгийн байгаль орчны үнэлгээ [БНБҮ]** Орос улсад болсон хэлэлцүүлэг болон Дэлхийн банкны зөвлөмжийн дагуу Монгол улсын Засгийн газар БНБҮ болон БОННҮ-г салангид авч үзэх шийдвэр гаргаж, БОННҮ болон ТЭЗҮ-г боловсруулж эхлэхээс өмнө БННҮ-г жичид боловсруулах юм. БОННҮ болон ТЭЗҮ-г зөвхөн БННҮ-ны шаардлага хангасан төслүүдийн хувьд боловсруулна. Гэхдээ, энэхүү шийдвэрийг хэлэлцүүлэг дууссаны дараа албан ёсоор зарлах болно.
4. **Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ [ХНҮ].** ХНҮ нь БННҮ-ний салшгүй хэсэг байх болно. Монгол улсын Засгийн газрын анхааран авч үзэж байгаа Шүрэн, Орхон болон бусад усан-техникийн төслүүд түүнчлэн Сэлэнгэ мөрний сав газар дахь байгаль орчин, нийгмийн нөлөөллийн асуудлыг тус бүрээр болон нэгдсэн байдлаар үнэлгээ хийх болно. 2017 оны 1 дүгээр сард Монгол улсын Засгийн газар Дэлхийн Өвийн төвд захидал илгээж БННҮ-ний хэсэг болгон ХНҮ-г эхлэн хийх шийдвэр гаргасаныг мэдэгдсэн.

ХАВСРАЛТ III

МОНГОЛ УЛС:

УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ

ДЭМЖИХ ТӨСӨЛ (P118109) БОЛОН ТҮҮНИЙ

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН (P145439)

ТУХАЙ ХЯНАЛТЫН ХОРООНД ИРҮҮЛСЭН

МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧИЛСЭН ТЭМДЭГЛЭЛ

2017 оны 7 дугаар сарын 7

МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧИЛСЭН ТЭМДЭГЛЭЛ

МОНГОЛ УЛСАД АЖИЛЛАСАН ХЯНАЛТЫН ХОРООНД:

УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ (P118109) БОЛОН УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ-НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ (P145439)

2017 оны 7 дугаар сарын 7

Монголд зохион байгуулсан нийтийн хэлэлцүүлгийн хураангуй \2017 оны 6 дугаар сарын 28 – 7 дугаар сарын 3\

1. Зорилт

2017 оны 6 дугаар сарын 28-наас 7 дугаар сарын 3-ны өдрүүдэд зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэг нь Шүрэн УЦС \Шүрэн УЦС\, Орхоны урсацын тохируулга болон Усан сан байгуулах \ОГУ\ төслүүдийн БННУ\БОННУ-ний Ажлын Даалгаварын \АД\ төслийг оролцогч талуудад танилцуулан хэлэлцүүлэх, санаа бодлыг нь сонсох, болон сонирхож байгаа асуултуудад хариу өгөх, чухам юу санааг нь зовоож байгааг олж мэдэх, оролцогч талуудын зөвлөмж, санал сэтгэгдлийг нь сонсож АД-ыг боловсронгуй болгох зорилт тавьсан.

2. Мэдээлэл бэлтгэх, тараах

МИНИС хэлэлцүүлэгийн багц материалыг³ монгол хэлээр бэлтгэж, хэлэлцүүлэг эхлэхээс 14 хоногийн өмнө орон нутагт нийтэд хүртээмжтэй газруудаар тарааж, МИНИС-н вэбсайтад⁴ байршуулсан. Хэлэлцүүлэгийн тухай зарлалыг хэд хэдэн телевиз, радио болон сонингуудаар түгээсэн.

³Хэлэлцүүлгийн тараасан багц баримт бичигт дараахв материалууд орсон: (i) хэлэлцэх асуудлын төсөл; (ii) МИНИС төслийн танилцуулга; (iii) Орхон гол дээр урсацын тохируулга бүхий усан сан байгуулах БННУ ба БОННУ-н АД-ын төсөл; (iv) Орхон гол дээр урсацын тохируулга бүхий усан сан байгуулах БННУ ба БОННУ-н АД-ын техникийн үзүүлэлтийн төсөл; (v) Орхон гол дээр урсацын тохируулга бүхий усан сан байгуулах БННУ ба БОННУ-н АД-ын техникийн бус хураангуй; (vi) Шүрэнгийн УЦС-ын БННУ болон БОННУ-н АД-ын төсөл; (vii) Шүрэнгийн УЦС-ын БННУ болон БОННУ-н АД-ын техникийн хураангуй; (viii) Шүрэнгийн УЦС-ын БННУ болон БОННУ-н АД-ын техникийн бус хураангуй; (ix) Олон улсын зөвлөх хорооны олон улсын гурван экспертийн (Байгаль орчны олон улсын мэрэгжилтэн, Нийгмийн асуудлын олон улсын мэрэгжилтэн, Далан, барилга байгууламжийн инженерийн чиглэлийн олон улсын) АД-н төсөл; (x) Дэлхийн Банкны мэдээллийг нээлттэй болгох ба нийтийн хэлэлцүүлэгийн төлөвлөлтийн санамж жагсаалт; (xi) МИНИС-н байнга тавигддаг асуултууд; (xii) МИНИС-н гомдол барагдуулах механизм.

⁴<http://www.minis.mn/en>

Хэлэлцүүлэгийн талаар сурталчилан танилцуулах болон хэлэлцүүлэгийн материалыг тараах асуудлаар орон нутгийн сум⁵, багийн засаг дарга нартай уулзан дараахь асуудлаар ярилцсан: \1\ нийтийн хэлэлцүүлгийн зорилго, \2\ хэлэлцүүлэх гэж байгаа төслүүдийн зорилго, \3\ хүлээж байгаа үр дүн, \4\ хэлэлцүүлэгийн багц мэдээллийг тараах болон АД-ын төслийн тухай мэдээллийг түгээх. Банкны ажилтнууд хэлэлцүүлэг болон материалыг тараах үйл ажиллагаанд ажиглагчаар оролцсон.

3. Нийтийн хэлэлцүүлэг

Улаанбаатар хот болон зургаан аймагт зохион байгуулсан хэлэлцүүлэгт нийт 1005 хүн оролцсон ба Хүснэгт 1-д тодорхой тусгав. Орон нутгийн засаг даргын тамгын газрын ажилтнууд, ТББ-ууд, хувийн хэвшил, орон нутгийн иргэд \сум, багийн төвийн иргэд, малчид\ болон санал болгож байгаа төслүүдэд хамааралтай байж болох иргэдийн төлөөлөл зэрэг хүмүүс оролцсон.

Хэлэлцүүлэг зохион байгуулах багт холбогдох салбаруудын эрдэмтэд, мэрэгжилтнүүд оролцсон. Хэлэлцүүлэгийн үеэр, төслийн зорилго, урьдчилсан судалгааны дүн, байгаль орчин, нийгэмд үзүүлж болох нөлөөллийн цар хүрээний судалгааг танилцуулсан. Бүс нутгийн байгаль орчны үнэлгээ \БНБҮ\ болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний \БОННҮ\ АД-тай холбоо бүхий янз бүрийн асуудал, тухайлбал ган, үер болон эдийн засаг-нийгмийн нөлөөлөл, техникийн болон байгаль орчны асуудлуудыг хамарсан. Хэлэлцүүлэгүүдэд Банкны ажилтнууд ажиглагчаар оролцсон.

Хүснэгт 1. Нийтийн хэлэлцүүлгийн хуваарь

#	Байрлал	Огноо	Нийт оролцогсод
Орхон гол дээр урсацын тохируулга бүхий усан байгуулах төсөл			634
1	Төв аймаг Дэлгэрхаан сум	2017.06.28	45
2	Төв аймаг Эрдэнэ сант сум	2017.06.28	80
3	Төв аймаг Дашинчилэн сум	2017.06.29	22
4	Булган аймаг Хишиг өндөр сум	2017.06.29	34
5	Булган аймаг Орхон сут	2017.06.30	84
6	Булган аймаг Булган сум	2017.06.30	31
7	Дундговь аймаг Хулд сум	2017.06.28	70
8	Дундговь аймаг Эрдэнэ далай сум	2017.06.28	80
9	Өмнөговь аймаг Цогт цэций сум	2017.06.29	70

⁵Аймаг сумдад, сум нь багт хуваагдана.

10	Өмнөговь аймаг Ханбогд сум	2017.06.30	50
11	Өмнөговь аймаг Даланзадгад сум	2017.07.01	68

Шүрэнгийн усан цахилгаан станц төсөл			239
12	Эрдэнэт хот \Орхон аймаг\	2017.06.28	126
13	Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгон + Хангал сумын Хялганат тосгоны Сэлэнгэмөрөн баг	2017.06.29	53
14	Булган аймгийн Сэлэнгэ сум	2017.06.29	17
15	Булган аймгийн Сэлэнгэ сумын Сангалтай\Атр\Цүүц багууд + Сэлэнгэ аймгийн Цагаан нуур сум	2017.06.29	43
Нэгдсэн хэлэлцүүлэг: Шүрэнгийн усан цахилгаан станц төсөл, Орхон гол дээр урсацын тохируулга бүхий усан байгуулах төсөл			132
16	Сэлэнгэ аймаг	2017.07.01	35
17	Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сум	2017.07.01	36
18	Сэлэнгэ аймгийн Хушаат сум	2017.07.01	21
19	Улаанбаатар	2017.07.03	40
Нийт			1005

4. Нийтийн хэлэлцүүлгийн үеэр гарсан санал хүсэлтийн хураангуй

Малчид болон оршин суугчдийн зүгээс нийгэм болон байгаль орчны нөлөөллийн асуудалд хамгийн их анхаарал хандуулж байсан ба тухайлбал, хамрагдах хүрээний хөрсний үржил шим, бэлчээр, түүхийн дурсгалт газрууд, ургамал амьтаны аймаг, усны чанар, загасны тооо хэмжээ болон газар тариалан, нүүдлийн мал аж ахуй эрхлэлт болон орон нутгийн иргэдийн амьжиргаанд үзүүлж болох сөрөг үр дагавар. Оролцогсодын зарим нь төслийг хэрэгжүүлэх хугацаа болон байрлалын \хамаарагдах нуур, бэлчээрийн зааг, хэзээ хэнийг нүүлгэн шилжүүлэх г.м\ талаар болон техникийн дизайны \ус дамжуулах хоолойн байрлал, санал болгож байгаа төслийн зорилго, хувилбарууд\ холбогдол бүхий асуултууд тавьж байсан. Оролцогсодын зарим нь газар хөдлөлтийн эрсдэл, уур амьсгалын өөрчлөлт, усны түвшин, судалгааны хэрэгжилт, Монгол, Оросын засгийн газар хоорондын хэлэлцээр зэргийг талаар санал сэтгэгдэлээ хуваалцаж байсан. Зарим нь танилцуулж байгаа төслүүдийг дэмжихгүй гэдгээ илэрхийлж байсан.

Шүрэнгийн УЦС болон Орхон гол дээр урсацын тохируулга бүхий усан сан байгуулах төслийн БННУ\БОННУ-ний АД-тай холбогдуулан оролцогсодын зүгээс тавьсан асуултууд, санал сэтгэгдэл болон санал зөвлөмжүүдийн бүрэн бичлэг хийгдсэн. Хэлэлцүүлгийн үеэр тавьсан

оролцогсодын санал сэтгэгдэл болон 7 дугаар сарын 17 хүртэл сунгасан 14 хоногийн туршид гарсан санал сэтгэгдлийн тэмдэглэл хийгдэх ба тавигдсан асуултууд\санал сэтгэгдлийн хариуг матрицаар бэлтгэн өгнө.

5. Хэлэлцүүлэгүүдийн ажиглалтын хураангуй

Монголд энэ удаа санал болгож байгаа төслүүдийн талаар МИНИС-н зохион байгуулсан хэлэлцүүлэгийн үйл ажиллагаа нь Банкны журмын шаардлагыг бүрэн хангасан гэж Менежмент үзэж байна.

\а\ Олон нийтийн хэлэлцүүлэгийг орон нутгийн удирдлагын тусламжтайгаар зохион байгуулсан.Тухайлбал хэлэлцүүлэгийн байрыг товлох, мэдээллийн материалуудыг тараах мөн түүнчлэнхэлэлцүүлгийг хамтран даргалсан.

\б\ Хэлэлцүүлэгт нийгмийннэгз бүрийн давхрагын төлөөлөл оролцсан, тухайлбал орон нутгийн засаг захиргаа, нөлөөлөлд өрөтөж болзошгүйгазар нутгийн иргэдийн төлөөлөл, ТББ\ИНБ-ууд болон хувийн хэвшлийн төлөөлөл оролцсон. Хэлэлцүүлэг болох газрыг орон нутгийн иргэд болон сонирхсон хүмүүст тодорхой зарласан \дийлэнхи тохиолдолд хэлэлцүүлгийг соёлын төвүүдэд хийсэн\ Хэлэлцүүлгийн бэлтгэлийг чамбай хангасан ба тараах материалуудыг сайн чанартай, хүрэлцэхүйц хэмжээгээр монгол хэлээр бэлтгэсэн ба үүнд: \1\ төслийн товч танилцуулга (зурагт хуудас); \2\ товхимол хэлбэрээр бэлтгэсэн АД; \3\ хэлэлцүүлэгт тавих илтгэлүүдийн хувь; \4\ хэлэлцүүлэгийн тухай мэдээлэл ба санал сэтгэгдэлийн маягт орно.

\в\ Илтгэлүүдийг мэргэжлийн бус хүмүүст зориулан бэлтгэсэн ба илтгэлүүдийн хэллэг, нэр томъёог бүх оролцогч талуудад ойлгомжтой байх хэлбэрээр бэлтгэсэн. Илтгэлүүдийг ойлгожтой болгох зорилгоор аудио систем ашигласан.

\г\ Оролцогсодод санал сэтгэгдэлээ илэрхийлэх хангалттай хугацаа болон боломж олгосон. Бүх асуултын бичлэгийг дуу хураагч болон видеогоор хийсэн. Түүнээс гадна, санал хүсэлтийн хариуг бичгээр өгч байх үүднээс 7 дугаар сарын 17 хүртэл “саналын дэвтэр” нээсэн. Хэлэлцүүлэгийн үеэр МИНИС-н санал гомдол хүлээн авч барагдуулах механизм болон хэрхэн холбоо барихыг тодорхой танилцуулсан.

\д\ Хэлэлцүүлэгүүд нь ямар нэг үймээн самуунгүй, журамтай, эмх цэгцтэй явагдсан. Хэлэлцүүлэгүүдийг Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа 6 дугаар сарын 26-нд хийхээр төлөвлөж байсныг цохон тэмдэглэж байна. Монгол улсын түүхэнд анх удаа хоёрдох шатны сонгууль явуулах нөхцөл байдал үүссэнээр 7 дугаар сарын 7-нд уг сонгуулийг явуулахаар товлосон. Энэ хугацаанд компанит ажил явуулахыг хуулиар хориглосон. Гэхдээ сонгуулийн явц хэлэлцүүлэгт үнэндээ бол ямар нэг байдлаар нөлөөлөөгүй бөгөөд харин нэг газар орон нутгийн захиргаа

хэлэлцүүлгийг цуцалсан. Тэр газарт иргэдтэйхийх хэлэлцүүлгийгхэрхэн зохион байгуулах талаар ТХН-тэй бид ярилцаж байна.

6. Дараагийн алхам

Хэлэлцүүлэгийн тайлан илтгэл болон хариултын матрицыг 9 дүгээр сарын эхээр бэлэн болгож, МИНИС-ын вэбсайтад байршуулна.

Хавсралт материал

2017 оны6 дугаар сарын 28-наас 7 дугаар сарын 3-нд Монгол улсад зохион байгуулсан хэлэлцүүлгүүдийн зурагнууд.







ХАВСРАЛТ IV

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСАД ТАРААСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГИЙН МАТЕРИАЛУУД

МИНИС ТУН-ээс ОХУ-д тараасан хэлэлцүүлгийн материал

1. Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн танилцуулга
2. Орхон голын урсцын тохируулга ба усан сангийн цогцолбор барих ажлын бүс нутгийн байгаль орчны үнэлгээ (БНБОУ) болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) –ний ажлын удирдамжууд (АУ)-ын төслүүд
3. Шүрэнгийн усан цахилгаан станцын төсөл (ШЦС)-ийн бүс нутгийн байгаль орчны үнэлгээ (БНБОУ) болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) –ний ажлын удирдамжууд (АУ)-ын төслүүд
4. Орхон голын урсцын тохируулга ба усан сангийн цогцолбор барих ажлын БНБОУ болон БОННУ-ний АУ-ын төслүүдийн техникийн хураангуй
5. ШЦС-ын БНБОУ болон БОННУ-ний АУ-ын төслүүдийн техникийн хураангуй
6. Орхон голын урсцын тохируулга ба усан сангийн цогцолбор барих ажлын БНБОУ болон БОННУ-ний АУ-ын төслүүдийн техникийн бус хураангуй
7. ШЦС-ын БНБОУ болон БОННУ-ний АУ-ын төслүүдийн техникийн бус хураангуй
8. Олон улсын зөвлөх хорооны ажлын удирдамжуудын төслүүд: олон улсын байгаль орчны мэргэжилтэн, олон улсын нийгмийн мэргэжилтэн мөн далан ба барилгын инженер
9. Дэлхийн Банкны мэдээллийг нийтэд ил болгох, олон нийтийн хэлэлцүүлэг төлөвлөх хяналтын хуудас
10. МИНИС төсөлд тавьдаг түгээмэл асуултууд
11. МИНИС төслийн гомдол шийдвэрлэх механизм